# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

- Шинжлэх ухаан технологийн тухай Монгол Улсын хууль
- Технологи дамжуулах тухай Монгол Улсын хууль
- Эмийн тухай Монгол Улсын хууль
- Дайчилгааны тухай Монгол Улсын хууль
- Дайны байдлын тухай Монгол Улсын хууль

6

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
1998 ОН

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

## ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР


Монгол Улсын Их Хурлын хэвлэл

1998 оны 6-р сар №6 /73/


ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


он улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд нэмэлт,
рчлөлт оруулах тухай 569
инжлэх ухаан, технологийн тухай 570
хнологи дамжуулах тухай 581
ийн тухай 588
ульд өөрчлөлт оруулах тухай 597
онгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай
ульд нэмэлт оруулах тухай 597
улийн заалт хүчингүй болсонд тооцох тухай 598
йчилгааны тухай 598
йны байдлын тухай 613


### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


гтоолд өөрчлөлт оруулах тухай № 42 628
им албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн
тоох тухай № 43 628
үгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн
тоох тухай № 44 629
окурорын албан тушаалын цалингийн хэмжээг
нэчлэн тогтоох тухай № 45 630
эсэн хуулийн цэцийн 06 тоот дүгнэлтийн тухай № 46 631
эсэн хуулийн цэцийн гишүүнээр нөхөн томилох тухай № 47 631
ал хураах комисс байгуулах тухай № 48 632
нгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох
ай № 49 632
им хүмүүсийг чөлөөлөх тухай № 50 633
нгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох
ай № 51 634
им хүмүүсийг ажлаас чөлөөлөх тухай № 52 634
ул мэндийн, Эмийн, Ариун цэврийн тухай хуулиудыг
элсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний
ай № 53 635
нхийлэгчийн хоригийн тухай № 54 636

23. Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай № 55
24. Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 57
25. Ажлаас чөлөөлөх тухай № 58
26. Хууль батлалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай № 59
27. Санал хураах комисс байгуулах тухай № 61
28. Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 62
29. Ажлаас чөлөөлөх тухай № 63
30. Нөхөн сонгууль зарлах тухай № 64
31. Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай № 65

## 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

32. Р. Шибаг "Алтан гадас" одонгоор нэхэн шагнах тухай № 34
33. В.М. Солнцевийг "Найрамдал" медалиар шагнах тухай № 35
34. В. С. Хохловыг "Найрамдал" медалиар шагнах тухай № 36
35. Жон Боклерийг "Найрамдал" медалиар шагнах тухай № 37
36. Кристин Мусисийг "Найрамдал" медалиар шагнах тухай № 38
37. Пол Окюстыг "Найрамдал" медалиар шагнах тухай № 52
38. ОХУ-ын зарим иргэдийг шагнах тухай № 53
39. Г. Т. Пличукийг "Найрамдал" медалиар шагнах тухай № 54
40. Д. Б. Улымжиевийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай № 68
41. Ү. Цэдэнбалд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай № 69
42. Ч. Орсоод Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай № 70
43. Б. Дамдиндоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай № 71
44. Ж. Гантөмөрт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай № 72
45. Л. Баттуулд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай № 73
46. А. Доржсүрэнд Монгол Улсын спортын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай № 74
47. Л. Гантөмөрт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай № 75
48. Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай № 76
49. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 77

## 4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

50. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай № 05
51. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 9, 14 дүгээр зүйлийн 1-ийг зөрчсөн эсэх тухай № 06

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

8 оны 4 дүгээр
ын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

## ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**I дүгээр зүйл**. Олон улсын гэрээний тухай хуульд дор дурдсан лгатай 3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийг тус тус сугэй:

I/ 3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:

5. "Олон улсын байгууллага" гэж улс болон Засгийн газар хоорондын і улсын байгууллагыг хэлнэ.

і."Нэгдэн орох баримт бичиг" гэж нэгэнт хүчин төгөлдөр болсон олон ын гэрээнд нэгдэн орохоор Монгол Улсын Их Хурлаас хууль гаргасныг лсон баримт бичгийг хэлнэ."

?/ 29 дүгээр зүйл:

29 дүгээр зүйл. Олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон санхүүжилт

Монгол Улсын Их Хурлаас олон улсын гэрээг соёрхон батлах, нэгдэж : Засгийн газраас олон улсын гэрээг батлах шийдвэр гаргахдаа йн олон улсын гэрээг орчуулах, хэвлэхтэй холбогдсон зардлыг йн байгууллага хариуцан төсөвтөө тусгаж санхүүжилтийн эх эрийг шийдвэрлэж байна."

**: дугаар зүйл**. Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн іх хэсгийн "олон улсын байгууллагатай" гэсний дараа "гадаадын иийн болон хувь этгээдтэй", 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн лбар" гэсний дараа "мэдэгдэл", мөн зүйлийн 1 дэх хэсгийн "соёрхон ах" гэсний дараа "нэгдэн орох", 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн рхон баталсан" гэсний дараа "нэгдэн орох шийдвэр гаргасан", угаар зүйлийн 3 дахь хэсгийн "төв байгууллага" гэсний дараа "тухайн і талт гэрээний заалт, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу" гэж ус нэмсугэй.

**дугаар зүйл**. Олон улсын гэрээний тухай хуулийн 2О дугаар ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

20 дугаар зүйл.Олон улсын гэрээнд хяналт тавих

. Монгол Улсын Их Хурал нь соёрхон баталсан, нэгдэн орсон олон н гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аа гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байна.

. Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах длаар байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж элтийг зохион байгуулж ажиллана.

. Зохицуулж буй асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу глагийн дарга олон улсын гэрээний биелэлтийг гаргаж жил бүрийн

6, 12 дугаар сарын 2О-ны дотор гадаад харилцааны асуудал эрхэ төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж байх бөгөөд гад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага с улсын гэрээний биелэлтийн явцыг нэгтгэн дүгнэж шаардлага тохиолдолд саналаа Засгийн газарт оруулж хэлэлцүүлнэ."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр — Улаанбаата хот

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллага оролцогчдын эрх, үүргийг тодорхойлж, энэхүү үйл ажиллага удирдлага, зарчим, санхүүжилттэй холбогдсон харилцааг зохицуул оршино.

**2 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомж**

2.1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тухай х тогтоомж нь Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцү гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуулиас өөрөөр за бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дур утгаар ойлгоно:

3.1.1. "технологи" гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгд болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зох

---

[1] Үндсэн хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дуг нийтлэгдсэн.

ллалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын г;

3.1.2. "шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа" гэж техник, логи, эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх, лэх ухаан, технологи, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн лборын үйл ажиллагааг хангах зорилгоор шинэ мэдлэгийг бий , хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг;

3.1.3. "эрдэм шинжилгээний ажлын үр дүн" гэж шинжлэх ухааны жиллагааны хүрээнд бий болсон шинэ мэдлэгийг илэрхийлсэн плийг;

3.1.4. "грант" гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон байгууллага урьдчилан тавьсан нөхцөлийнхөө дагуу тодорхой гаа, шинжилгээний ажил явуулахаар шинжлэх ухааны үйл агаанд оролцогчдод буцалтгүй, эргэн төлүүлэхгүйгээр олгож ı мөнгөн болон бусад хөрөнгийг;

3.1.5. "эрдэм шинжилгээний байгууллага" гэж шинжлэх ухаан, логийг хөгжүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион ıт, нарийн мэргэжлийн судалгаа гүйцэтгэдэг, өндөр мэргэжлийн эч бэлтгэх үйл ажиллагаанд оролцдог байгууллагыг.

**,үгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим**

4.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд дараахь ыг баримтална:

4.1.1. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч нь шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын чиглэл, тэдгээрийг ;үүлэх арга хэлбэрийг чөлөөтэй сонгох, хэрэгжүүлэх;

4.1.2. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнгээс амаарах үндэслэл бүхий эрсдлийг төр болон бусад жүүлэгчээс хүлээн зөвшөөрөх;

4.1.3. эрдэм шинжилгээний ажил, түүний сонгон шалгаруулалт нь г өрсөлдөөнд үндэслэх, ил тод, нээлттэй байх;

4.1.4. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд өмчийн ийг харгалзахгүйгээр аливаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэд гэй оролцох.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг зохицуулах

**дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо**

нжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо згийн газар, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн ааны төв байгууллага, шинжлэх ухаан, технологийн үндсэний

зөвлөл, Монгол Улсын шинжлэх ухааны академи, их, дээд сург шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл /корпораци/, э шинжилгээний хүрээлэн, байгууллагаас бүрдэнэ.

**6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

6.1. Засгийн газар шинжлэх ухаан, технологийн ажиллагаатай холбогдсон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар тө баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зо байгуулах,

6.1.2. улсын захиалгатай шинжлэх ухаан, техноло хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, судалгаа /цаашид "шинжлэх у технологийн төсөл" гэх/, түүний үр дүнг хэрэгжүүлэхэд шаард хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоож, жил бү эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын т тусгуулах;

6.1.3. төрийн өмчийн эрдэм шинжилгээний бие д байгууллага байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;

6.1.4. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллаг холбоотой нийтлэг мөрдөгдөх дүрэм, журмыг батлах;

6.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх

**7 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

7.1. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн тө захиргааны төв байгууллага шинжлэх ухаан, технологийн т дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс бари бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

7.1.2. төрийн захиргааны төв болон орон нутгийн захир байгууллагаас шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн удирдлагаар хангах;

7.1.3. эрдэм шинжилгээний байгууллагад зэрэглэл тогтоох

7.1.4. шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэ сүлжээг зохион байгуулах;

7.1.5. улсын захиалгатай шинжлэх ухаан, технологийн тө сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

7.1.6. зохих хууль тогтоомжид заасны дагуу оюуны өм хамгаалах, баталгаажуулах арга хэмжээ авах;

7.1.7. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар г орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

7.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

**угаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл**

8.1. Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар : баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг уялдуулан уулах, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар зөвлөмж үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн ний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-тэй байна.

8.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

8.3. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.3.1. улсын нэрийн өмнөөс төрийн захиргааны төв ллагуудын захиалсны дагуу боловсруулан сонгон шалгаруулсан лэх ухаан, технологийн төслийг батлах;

8.3.2. эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог үлэх талаар зөвлөмж гаргах;

8.3.3. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх ийг тодорхойлох;

8.3.4. шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр тэсэн шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг рлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглаж байгаа тухай агчийн тайлан, мэдээллийг жил бүр хэлэлцэн санал, зөвлөмж .

8.3.5. хуульд заасан бусад чиг үүрэг.

**угээр зүйл. Шинжлэх ухааны академи**

9.1. Монгол Улсын шинжлэх ухааны академийн үйл ажиллагаатай дсон харилцааг Монгол Улсын шинжлэх ухааны академийн эрх йдлын тухай хуулиар зохицуулна.

9.2. Монгол Улсын шинжлэх ухааны академи нь Зөвлөлийн тийг үндэслэн шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн ийг өөрийн бүтцэд байгуулж болно.

9.3. Төрийн бус өмчийн шинжлэх ухааны академийн үйл гаатай холбогдсон харилцааг Төрийн бус байгууллагын тухай р[1] зохицуулна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчид, тэдгээрийн эрх, үүрэг

**дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч**

---

[1] н бус байгууллагын тухай хууль, "Төрийн мэдээлэл" ийн 1997 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

10.1.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд дар эттэд оролцоно:

10.1.1. Шинжлэх ухаан, технологийн сан;

10.1.2. эрдэм шинжилгээний байгууллага;

10.1.3. аж ахуйн нэгж, байгууллага;

10.1.4. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хү

**11 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн сан**

11.1.Шинжлэх ухаан, технологийн сан /цаашид "Сан" гэх/ нь у захиалгатай шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлэх, төс үр дүнг үнэлэх байгууллага мөн.

11.2. Сангийн үйл ажиллагааны дүрмийг Зөвлөл батална.

11.3. Сангийн захирлыг Зөвлөл томилж, чөлөөлнө.

11.4. Сангийн захирал нь Зөвлөлд ажлаа хариуцаж тайлагнан

11.5. Сан дараахь асуудлыг эрхэлнэ:

11.5.1. улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зо бүтээх ажлыг санхүүжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулах;

11.5.2. олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байда танилцах, үр дүнд нь хяналт магадлагаа хийлгэх, үнэлгээ, дү гаргуулах, шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн шийдвэр гарах хү санхүүжилтийг түр зогсоох;

11.5.3. шинжлэх ухаан, технологийн мэдээлэл авах, э шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах, мэргэжи бэлтгэх арга хэмжээг санхүүжүүлэх;

11.5.4. шинжлэх ухаан, технологийн төслийн зардал, хө оруулалтыг хуваарилах талаар санал гаргах;

11.5.5.Сангийн хөрөнгийн төсвийн бус эх үүсвэрийг нэмэгдү эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээ, туршилт, зо бүтээх ажил гүйцэтгэх, түүний үр дүнг ашиглахад зориулан төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжилт хийх, олгосон хөрөнгий төлүүлэх талаар арга хэмжээ авах;

11.5.6. шинжлэх ухаан, технологийн төслийн а санхүүжилтийн хөрөнгийн ашиглалтад холбогдох мэргэж байгууллагатай хамтран хяналт тавьж, зохицуулалт хийх, ил зөрчлийг арилгах арга хэмжээ авах.

**12 дугаар зүйл. Эрдэм шинжилгээний байгууллага**

12.1. Эрдэм шинжилгээний байгууллагыг өмчийн хэ харгалзахгүйгээр дараахь хэлбэрээр байгуулан ажиллуулж болно:

12.1.1. хүрээлэн, төв, лаборатори;

12.1.2. дээд боловсролын байгууллага;

12.1.3.шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн н /корпораци/.

12.2. Эрдэм шинжилгээний байгууллага нь удирдлага, э байгуулалтын бүтцээ өөрөө тогтооно.

12.3. Дээд боловсролын байгууллагыг эрдэм шинжилг байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинж

12.3. Дээд боловсролын байгууллагыг эрдэм шинжилгээний гууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх эн, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

**13 дугаар зүйл. Эрдэм шинжилгээний байгууллагыг байгуулах**

13.1. Эрдэм шинжилгээний дараахь байгууллагыг байгуулах удлыг дор дурдсан этгээд шийдвэрлэнэ:

13.1.1. төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага байгуулах удлыг Засгийн газар;

13.1.2. төрийн өмчийн оролцоотой эрдэм шинжилгээний гууллагыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн ргааны төв байгууллага үүсгэн байгуулагчтай хамтран;

13.1.3. төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллага гуулахыг үүсгэн байгуулагч хууль тогтоомжид нийцүүлэн дангаар тус шийдвэрлэнэ.

13.2. Эрдэм шинжилгээний байгууллагыг шинжлэх ухаан, нологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын гэлд бүртгэнэ.

13.3. Эрдэм шинжилгээний байгууллагын үүсгэн байгуулагч нь эм шинжилгээний байгууллагыг зориулалтын барилга байгууламж, эг тоноглол, багаж хэрэгсэл, туршилтын сэЙЮЗэ, мал, амьтан, мал зэргээр хангана.

13.4. Эрдэм шинжилгээний байгууллага нь үйл ажиллагааныхаа лго, агуулгыг илэрхийлсэн оноосон нэртэй байна.

**14 дүгээр зүйл. Хүрээлэн, төв, лаборатори**

14.1. Хүрээлэн, төв, лаборатори нь шинжлэх ухаан, технологийн ажиллагааг дагнан эрхлэх эрдэм шинжилгээний байгууллага мөн.

14.2. Хүрээлэн судалгаа, шинжилгээний ажлын чиглэл болон гэжүүлж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц, үнг тогтмол авч хэлэлцэн тэдгээрийн шинжлэх ухааны түвшин, ач богдлыг нь үнэлж, дүгнэж байх үүрэг бүхий, тухайн салбарын мтэн, мэргэжилтнийг оролцуулсан эрдмийн зөвлөл байгуулан ллуулна.

**5 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл /корпораци/**

15.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээлт, үйлдвэрлэл, аж н үйл ажиллагааг хослон явуулдаг байгууллагыг шинжлэх ухаан, ологи, үйлдвэрлэлийн нэгдэл /корпораци/ гэнэ.

15.2. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн лдэхүүнд эрдэм шинжилгээний болон бусад байгууллага нэгдэж ю.

15.3. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл нь оглох хууль тогтоомжийн дагуу байгуулсан төлөөлөн удирдах влөөр дамжуулан удирдлагаа хэрэгжүүлнэ.

15.4. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн эр
шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажилтай холбогдсон харилцааг
хуулиар, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон харилц
аж ахуйн нэгж, татварын тухай холбогдох хууль тогтоомж
зохицуулна.

15.5. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдл
туршилтын бүтээгдэхүүнийг борлуулсны орлогыг тухайн нэгдлийн эр
шинжилгээ, туршилтын баазыг бэхжүүлэхэд зарцуулна.

**16 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг**

16.1.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцо
дараах эрх эдэлнэ:

16.1.1. онолын суурь судалгаа, шинжлэх ухаан, технологийн тө
гүйцэтгэх сонгон шалгаруулалтад оролцох;

16.1.2. хуулиар хамгаалсан нууцаас бусад мэдээллийг чөлөө
олж авах;

16.1.3. холбогдох хууль тогтоомжоор төрийн буюу байгууллa
нууцад хамааруулаагүй тохиолдолд эрдэм шинжилгээ, туршилт, зох
бүтээх ажлынхаа үр дүнг нийтэд мэдээлэх;

16.1.4. гадаад орон, олон улсын байгууллагын шинжлэх ух
технологийн хамтын ажиллагаанд оролцох, эрдэм шинжилгээний б
хуралд судалгааны ажлынхаа үр дүнг илтгэх;

16.1.5. олон улсын болон дотоод, гадаадын шинжлэх уха
байгууллага, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх, тэдгээр
удирдлагад сонгогдох;

16.1.6. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц б
үр дүн нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх
байгаа нь тогтоогдвол уг ажлаа зогсоож, түүний улмаас учирч бо
хохирлын талаар захиалагч, санхүүжүүлэгч, холбогдох бу
байгууллагад мэдэгдэх;

16.1.7. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр д
харилцан солилцох, зуучлах.

16.2. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцо
дараах үүрэгтэй:

16.2.1. шинжлэх ухаан, технологийн төсөл, туршилт, гра
бодитой хэрэгжүүлэх;

16.2.2. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайл
шинжлэх ухаан, технологийн мэдээллийн санд зохих журмын дагуу
хадгалуулах;

16.2.3. эрхэлсэн ажлынхаа чиглэлээр хурал, сургалт, семи
зохион байгуулах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр ханга

16.2.4. эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, санхүүжилт
хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүл
байгууллагын шаардсан тухай бүр үнэн зөв гаргаж өгөх.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх

**7 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр**

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх эр нь Сангийн хөрөнгө, орон нутгийн төсөв, Монгол Улсын иргэн, адын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллагаас жлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зориулан олгосон нгө, хандив, тусламжаас бүрдэнэ.

**8 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зарчим**

18.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дараахь маар санхүүжүүлнэ:

18.1.1. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын ь судалгаа, төслийг тэргүүн ээлжинд;

18.1.2. улсын захиалгатай шинжлэх ухаан, технологийн төслийг ийн хөрөнгөөр;

18.1.3. орон нутгийн засаг захиргааны байгууллагын захиалгатай м шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг орон нутгийн төсвийн нгөөр;

18.1.4. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгатай эрдэм илгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагчийн хөрөнгөөр.

**9 дүгээр зүйл. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт**

19.1. Сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

19.1.1.шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтэд улан батлагдсан улсын төсвийн хөрөнгө. Фанд олгож буй улсын ийн хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1,5 хувиас үй байна;

19.1.2. шинжлэх ухаан, технологийн салбарын хөрөнгө залтын зардал;

19.1.3. төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага буюу ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион х ажлын үр дүнг борлуулсны орлого, нэвтрүүлж ашигласнаас үр ашгаас энэ хуулийн 23.2.5-д заасан хэмжээгээр тогтоосон

19.1.4. дотоод, гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн иргэдийн хандив, тусламж;

19.1.5. өөрийн үйл ажиллагааны орлого.

**дугаар зүйл. Сангийн хөрөнгийн зарцуулалт**

20.1. Сангийн хөрөнгийг шинжлэх ухаан, технологийн дараахь үйл загааг санхүүжүүлэхэд зарцуулна:

20.1.1. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онол суурь судалгаа;

20.1.2. улсын захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл.

**21 дүгээр зүйл. Сангийн тусгай зориулалттай нөөц хөрөнгө**

21.1. Цаг үеийн зайлшгүй шаардлагатай шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа явуулах, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг ашиглах зориулалтаар Сангийн хөрөнгө тодорхой хувиар нөөц байгуулна.

21.2. Нөөцөд авах Сангийн хөрөнгийн хувь хэмжээг Зөвлөл ж бүр тогтооно.

21.3. Сангийн нөөц хөрөнгийг зарцуулах тухай шийдвэр шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гиш гаргана.

**22 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх**

22.1. Сангийн болон орон нутгийн хөрөнгөөр гүйцэтгэх эрд шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг Засгийн газраас батал журмын дагуу хянан магадлагаа хийж сонгон шалгаруулна.

22.2. Зохих журмын дагуу сонгон авсан эрдэм шинжил туршилт, зохион бүтээх ажлыг санхүүжүүлэхэд олгох хөрөнгийн хэмж Зөвлөл тогтооно.

22.3. Улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зох бүтээх ажлыг гүйцэтгүүлэх төслийн захиалагч нь төрийн захиргааны байгууллага байна. Захиалагч нь батлсан төслийг санхүүжүүлэх С төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй тус тус гэрээ байгуулна.

22.4. Онолын суурь судалгааг байгууллагыг санхүүжүүлэх, гр олгох хэлбэрээр санхүүжүүлж болно.

22.5 Орон нутгийн засаг захиргааны байгууллагын захиалга эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүн нь хэд хэ бүс нутаг болон нийт улсын хэмжээнд хэрэглэгдэхээр бол түүн Сангийн хөрөнгөөс санхүүжүүлж болно.

22.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар гүйцэт эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжилт захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

22.7. Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын бари байгууламж, сорилт, туршилтын зориулалттай тоног төхөөрөмж хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон зардлыг зохих журмын да улсын төсөвт тусгуулах, санхүүжүүлэх асуудлыг санхүүгийн асуу эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

**23 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн төслийн захиалагчийн эрх, үүрэг**

23.1. Шинжлэх ухаан, технологийн төслийн захиалагч дара эрх эдэлнэ:

23.1.1.шинжлэх ухаан, технологийн төслийн санхүүжилтийн энгийн хэмжээг нэмэх буюу хасах асуудлыг Зөвлөлд танилцуулж ідвэрлүүлэх;

23.1.2. гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол ийг гүйцэтгэх явцад бий болсон үр дүнг өмчлөх. Ингэхдээ гүйцэтгэгч эл хэрэгжүүлэх явцад зохиогчийн эрхэд хамаарах оюуны үнэт зүйл ээсэн бол үг бүтээлтэй холбогдсон зохиогчийн эрхийн амины эрхийн эд захиалагч аливаа эрх эдлэхгүй;

23.1.3. төслийн явц, гүйцэтгэлийн болон санхүүжилтийн хөрөнгийн иглалтын тайлан, мэдээг гүйцэтгэгчээс гаргуулан авах;

23.1.4. төслийн санхүүжилтийн ашиглалтад аудитын хяналт лгэж дүгнэлт гаргуулах;

23.1.5. төслийн гүйцэтгэл гэрээнд заасан шаардлага хангахгүй юлдолд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлах, төслийн үүжилтийн хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;

23.1.6. төслийн гүйцэтгэлтэй холбогдсон маргааныг холбогдох ууллагад тавьж шийдвэрлүүлэх.

23.2. Улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион эх ажлын захиалагч болох төрийн захиргааны төв байгууллага захь үүрэгтэй:

23.2.1. захиалсан шинжлэх ухаан, технологийн төслийг нь үүжүүлэх Сантай гэрээ байгуулах;

23.2.2. Сангаас олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын алд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг й бүр авч хэрэгжүүлэх;

23.2.3. захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ынхаа гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, илэрсэн дутагдлыг арилгах длыг гүйцэтгэгчтэй хамтран шийдвэрлэх;

23.2.4. захиалсан ажлынхаа үр дүнг гүйцэтгэгчээс хүлээн авснаас и 2 жилд багтаан түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах арга кээ авах;

23.2.5. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үр дүнг уулсны орлого, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашигласны й 3 жилийн дундаж үр ашгийн 15 хүртэлх хувийг Сантай уулсан гэрээнд заасны дагуу түүнд шилжүүлэх.

23.3. Захиалагчийн буруутай үйл ажиллагааны улмаас этгэгчийн өмнө үүссэн хариуцлагыг Сан хүлээхгүй.

**4 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

24.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа гүйцэтгэгч захь эрх эдэлнэ:

24.1.1.гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ын хэмжээг үндэслэн санхүүжилтийн хөрөнгийг нэмэгдүүлэх асуудлыг алагчид тавьж шийдвэрлүүлэх;

24.1.2. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх аж санхүүжилтийг цаг тухайд нь хийхийг захиалагч, санхүүжүүлэгч шаардах;

24.1.3. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх аж санхүүжилт хийгдэхгүй байх буюу гэрээнд заасан хугацаанаас удааш нөхцөлд захиалагчтай байгуулсан гэрээг цуцлах;

24.1.4. захиалгаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, турш зохион бүтээх ажлынхаа үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигла эхний 3 жилийн дундаж үр ашгийн 15 хүртэл хувьтай тэн урамшууллыг захиалагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу нэг авах.

24.2. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэгч Иргэний хуулийн[1] 305 дугаар зүйлтэй нийцүүлэн захиалаг байгуулсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэ гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх үүрэгтэй.

24.3. Захиалагчтай байгуулсан гэрээнд эрдэм шинжил туршилт, зохион бүтээх ажлын явцад гэрээнд заасан үр дүнд х боломжгүй нь нотлогдсон, эсхүл давагдашгүй хүчин з гүйцэтгэгч нь нас барсан зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар уг аж цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсон бол энэ туха захиалагчид даруй мэдэгдэх гүйцэтгэгчийн үүрэг, цаашид хэрэгжэ тодорхой заана.

24.4. Гүйцэтгэгч захиалгат ажлаа гүйцэтгээгүй буюу д гүйцэтгэсэн, үр дүн нь чанарын шаардлага хангаагүй зэр захиалагчтай байгуулсан гэрээнд заасан үүргээ биелүүлэ тохиолдолд доголдлыг арилгах, чанарын зохих түвшинд хү ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх, олгосон хөрөнгийг нөхөн т зэрэг гүйцэтгэгчийн хүлээх хариуцлагыг гэрээнд тодорхой заана.

24.5.Гүйцэтгэгч нь гадаадын болон Монгол Улсын аж ахуйн н байгууллага, иргэний хөрөнгөөр гүйцэтгэж буй эрдэм шинжил туршилт, зохион бүтээх ажлын сэдвийг шинжлэх ухаан, технолог асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

24.6. Захиалагч гэрээнд заасан нөхцөлөө биелүүлэ санхүүжилтийг хугацаанд нь хийгээгүйн улмаас төслийн а зогссон буюу дутуу биелсний хариуцлагыг гүйцэтгэгч хүлээ бөгөөд өөрт нь учирсан хохирлыг захиалагч хариуцна.

---

[1] Иргэний хууль. "Ардын эрх" сонины 1994 оны 257, 258; 1995 он 1,2; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дугаарт тус тус нийтлэгдсэн.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа**

нгол Улсын нутаг дэвсгэр дээр зохих журмын дагуу гадаадын олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор шинжилгээний хамтарсан төсөл хэрэгжүүлж, байгууллага байгуулж

**дугаар зүйл.** Хууль хүчин төгөлдөр болох

э хуулийг 1998 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж ено.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ны 5 дугаар 7-ны өдөр Улаанбаатар хот

## ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**үгээр зүйл.** Хуулийн зорилт

хуулийн зорилт нь технологи дамжуулах үйл ажиллагааны , технологийн түвшний үнэлгээ хийх, технологи дамжуулах үйл эгаанд тавигдах шаардлагыг тодорхойлж, технологи дамжуулах-тбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**ргаар зүйл. Технологи дамжуулах тухай хууль тогтоомж**

2.1. Технологи дамжуулах тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1] ын тухай хууль[2] болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

---

эн хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт гдсэн.

тын тухай хууль. "Ардын эрх" сонины 1993 оны 104, "Төрийн эл" сэтгүүлийн 1993 оны 4-5 дугаарт тус тус нийтлэгдсэн.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд заасн өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурд утгаар ойлгоно:

3.1.1. "технологи" гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэх болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зох байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргууд цогцыг;

3.1.2. "технологи дамжуулах" гэж технологи эзэмшигч өөр технологийг ашиглах эрхийг бусад иргэн, хуулийн этгээдэд гэрээ үндсэн дээр шилжүүлэх үйл ажиллагааны цогцолборыг;

3.1.3. "технологийн горим" гэж хүний тодорхой зорилго бүхий ажиллагааг зохицуулан хэрэгжүүлэхэд чиглэгдсэн, шинжлэх уха үндэслэлтэй тогтоосон физик, хими, биологийн үйл явц болон хүний ажиллагаанд суурилсан үйлдлүүдийн цогцолборыг;

3.1.4. "ноу-хау" гэж үйлдвэрлэл, удирдлага, худалдаа, санхүүг үнэ цэнэ бүхий бөгөөд хуулиар эрхийн хамгаалалт хийгдээ нууцлагдсан, эзэмшиж ашиглахад тодорхой мэргэшил шаардаг аливаа мэдлэг, туршлагыг.

**4 дүгээр зүйл. Технологи дамжуулах үйл ажиллагааны зарчим**

4.1.Технологи дамжуулах үйл ажиллагаанд дараахь зар баримтална:

4.1.1. технологи дамжуулах үйл ажиллагаа нь шинжлэх уха технологийн талаар төрөөс баримтлах бодлогод нийцсэн байх;

4.1.2. технологи дамжуулах үйл ажиллагаанд төрийн зохицуул чөлөөт өрсөлдөөнийг хослуулах;

4.1.3. дамжуулах технологи нь байгаль орчин, хүний эрүүл м мал, амьтанд сөрөг нөлөөгүй байх;

4.1.4. техник, технологийн сүүлийн үеийн ололтыг ашигла чиглэгдсэн байх;

4.1.5. эдийн засгийн хөшүүргээр технологи дамжуулах ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх;

4.1.6. технологи дамжуулах үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн н байгууллага чөлөөтэй оролцох.

**5 дугаар зүйл. Технологи дамжуулах талаархи Засгийн газрын бүрэн эрх**

5.1.Технологи дамжуулах талаар Засгийн газар дараахь б эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. технологи дамжуулах талаар төрөөс баримтлах бодл хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын технолог шинэчлэлийг эдийн засгийн баталгаагаар хангах;

5.1.3. технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчид үзүү урамшуулалт, хөнгөлөлт, тэдгээрийн хэлбэр, хэмжээг тогтоох;

5.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

**6 дугаар зүйл. Технологи дамжуулах талаархи технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

6.1. Технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв ігуулллага нь технологи дамжуулахтай холбогдсон дараахь бүрэн ийг хэрэгжүүлнэ:

6.1.1. технологи дамжуулах хууль тогтоомжийн биелэлтийг гуулах, хяналт тавих, технологи дамжуулах үйл ажиллагааг шинжлэх ан, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлоготой цүүлэн зохицуулах;

6.1.2. технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох, богдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх;

6.1.3. технологи дамжуулахтай холбогдох мэдээллээр хангах ıыг зохион байгуулах;

6.1.4. тэргүүний технологи нэвтрүүлэх асуудлаар холбогдох гууллагуудтай хамтран төсөл зарлаж шалгаруулах, тэргүүний нологи ашиглах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал, зачилгыг дэмжих;

6.1.5. технологи эзэмшигчийн эрхийг хамгаалах асуудлы ıцуулах;

6.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Технологийн түвшний үнэлгээ

**7 дугаар зүйл. Технологийн түвшний үнэлгээ**

7.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглаж байга нологийнх нь улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль инд хохирол учруулбал, эсхүл тухайн чиглэлийн технологи жуулахыг хянаж байхаар Засгийн газар хооронды болон Монгол ын нэгдсэн бусад олон улсын гэрээ хэлэлцээрт заасан бол уг нологид төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан эрдэм ıжилгээний байгууллагаар үнэлгээ хийлгүүлнэ.

7.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь шинээр хэрэглэх нологийнхоо түвшинд 7.1-д заасан байгууллагаар үнэлгээ ıгүүлж болно.

7.3. Эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага технологийн ıинг үнэлэхдээ дараахь үзүүлэлтийг харгалзана:

7.3.1. технологийн техникийн үндсэн үзүүлэлтүүдийг ижил төрлийн нологийн харгалзах үзүүлэлтүүдтэй харьцуулан тогтоосон үнэлэлт;

7.3.2. технологийг ашигласнаас байгаль орчин, хүний эрүүл ı, мал, амьтан, үйлдвэрлэлийн нөхцөлд үзүүлж болох эерэг, сөрөг

болзошгүй нөлөөлөл, сөрөг үр дагаврыг бууруулах зөвлөмж;

7.3.3. технологийг ашигласны эдийн засгийн үзүүлэлтүүд;

7.3.4. бүтээгдэхүүний стандарт, чанар, аюулгүй байдлын үзүүлэ

7.3.5. технологийг ашиглахад шаардагдах мэргэжилтний хүрэлц хангамж;

7.3.6. тухайн технологийн онцлогтой холбогдох бусад үзүүлэлт.

7.4. Технологийн түвшинг үнэлэх эрдэм шинжилгээн байгууллага нь үнэлгээ хийж байгаа технологийн нууцыг чандл хадгалах үүрэгтэй бөгөөд хийсэн үнэлгээнийхээ талаар батла гаргана.

7.5. Холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага технологи түвшингийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичиг, бус зүйлийг саадгүй бүрдүүлж өгч, үнэлгээ хийлгэвэл зардлыг хариуцна.

7.6. Технологийн түвшний үнэлгээ хийсний дараа технологи асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага туха технологийг цаашид ашиглахыг хориглох талаар шийдвэр гарг болно.

7.7. Технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээн хэмжээг тогтоох аргачлалыг төрийн захиргааны төв байгууллa тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Технологи дамжуулах

**8 дугаар зүйл. Дамжуулах технологид хамаарах зүйл**

8.1. Дамжуулах технологид дараахь зүйл хамаарна:

8.1.1. технологийн горим, үйл ажиллагааны нөхцөл;

8.1.2. технологийн шат дамжлагын дэс дараалал, горим, бүрд хэсгийн талаархи зөвлөгөө, үйлчилгээ;

8.1.3. технологи нэвтрүүлэхэд шаардагдах техник, то төхөөрөмж;

8.1.4. шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээний үр д

8.1.5. патент, лиценз, бүтээгдэхүүний загвар;

8.1.6. ноу-хау.

**9 дүгээр зүйл. Дамжуулах технологид тавих шаардлага**

9.1. Дамжуулах технологи нь дараахь шаардлагын холбог үзүүлэлтийг хангасан байна:

9.1.1. Монгол Улсын болон олон улсын стандартын үзүүлэ шаардлагад нийцсэн байх;

9.1.2. эрчим хүч, материал, түүхий эд хэмнэх, бүтээгдэхүү өртөг, зардлыг хямдруулах;

9.1.3. түүхий эдийг иж бүрэн боловсруулж хэрэглэх, хаягдал технологи нэвтрүүлэх, хоёрдогч түүхий эдийг дахин боловсруул

глах боломжийг бий болгох;

9.1.4. үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэж байгаа эгдэхүүн нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал амьтанд сөрөг өөгүй байх;

9.1.5. дамжуулж байгаа технологийг хэрэгжүүлэх тодорхой үе шат г шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үндэслэлтэй эрхойлсон байх;

9.1.6. хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын зэрэг нологийн бүрдэл хэсгүүдийн харьцааг оновчтой тогтоох, тэдгээрийг шид боловсронгуй болгох нөхцөл, боломжийг харгалзах.

**10 дугаар зүйл. Дамжуулахыг хориглох технологи**

Байгаль орчин, хүнд үзүүлэх нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү сөрөг нөлөө үзүүлэхүйц технологийг дамжуулахыг иглоно.

**11 дүгээр зүйл. Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчийн эрх**

11.1.Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч дараахь эрх нэ:

11.1.1. хууль тогтоомжоор хориглосноос бусад технологи жуулах үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх;

11.1.2. технологи дамжуулахтай холбогдсон мэдээлэл авах;

11.1.3. технологи дамжуулах үйл ажиллагааны хүрээнд зуучлах, даар зуучлуулах;

11.1.4. дотоод, гадаадын болон олон улсын байгууллага, иргэнтэй гран ажиллах, туршлага солилцох, уулзалт, семинар, хурал зохион уулах.

**2 дугаар зүйл. Технологи дамжуулах гэрээ**

12.1. Технологи дамжуулах үйл ажиллагааг лицензийн гэрээгээр эжүүлнэ.

12.2. Технологи дамжуулах гэрээнд дараахь асуудлыг тусгана:

12.2.1.үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаатай холбогдсон хау болон нийлүүлэх бараа материал, түүхий эд, үйлчилгээний э, хэмжээ;

12.2.2. патент, барааны тэмдгийг ашиглах нөхцөл;

12.2.3. технологийг ашиглах, боловсронгуй болгох, түүнтэй югдон үүсэх давуу эрхийн тухай асуудал;

12.2.4. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах нөхцөл, талаар харилцан хүлээх үүрэг;

12.2.5. технологи нийлүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах, элгэн өгөх, үйлчилгээ хийх нөхцөл;

12.2.6. технологи, тоног төхөөрөмж, тэдгээрийн үйлчилгээний лгаат хугацааг нотолсон худалдагч талын батламж;

12.2.7. дамжуулж байгаа технологитой холбогдсон болон түүнийг всронгуй болгосон тухай мэдээллээр хангах асуудал;

12.2.8. гэрээнд заасан үүргийг биелүүлэх талаар талуудын хүлээх уцлага, учирсан хохирлыг нөхөн төлөх асуудал;

12.2.9. технологийн нууцыг хадгалах болзол, нөхцөл;

12.2.10. маргааныг шийдвэрлэх журам;

12.2.11. технологи худалдан авах үнэ, лицензийн төлбөр, тө нөхцөл, хэлбэр;

12.2.12. дамжуулсан технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүү борлуулах болон үйлчилгээ явуулах газар нутаг;

12.2.13. гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа.

12.2.14. бусад.

12.3. Технологийн нууцыг чандлан хадгалах үүргийг тал харилцан хүлээж, учирсан хохирлыг хэрхэхийг гэрээнд тодорхой заа

**13 дугаар зүйл. Технологи дамжуулах гэрээнд хязгаарлалт тавихыг хориглох**

13.1. Талууд технологи дамжуулах гэрээ байгуулахдаа дар харилцааны талаар хязгаарлалт харилцан тавихыг хориглоно:

13.1.1. технологийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүү гуравдагч этгээдэд экспортлох;

13.1.2. бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоох, үйлдвэрлэл технологийг өөрчлөх;

13.1.3. гуравдагч орноос өрсөлдөх чадвартай тэргүүний техно авах;

13.1.4. технологи дамжуулагч тал үүргээ биелүүлэх болом болсон нь батлагдсан нөхцөлд бусад байгууллагаас материал, түүхий тоног төхөөрөмж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ худал авах;

13.1.5. гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээний хуга дууссаны дараа технологийг чөлөөтэй ашиглах.

**14 дүгээр зүйл. Технологи дамжуулах гэрээг бүртгүүлэх**

14.1. Технологи дамжуулах гэрээг оюуны өмчийн асу эрхэлсэн байгууллагад бүртгүүлнэ.

14.2. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага нь у улсын буюу Монгол Улсын стандартын шаардлагад нийцэ технологийг гадаад орноос оруулах, шинээр хэрэглэх тухай г бүртгэхдээ дараахь үнэлгээ, дүгнэлтийн аль нэгийг үндэс болго

14.2.1. хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын талаар э мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулла дүгнэлт;

14.2.2. мал эмнэлэг, үржил, ургамал, газар тариалан үйлдвэрлэлийн технологи дамжуулж байгаа тохиолдолд хөдө аахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулла дүгнэлт;

14.2.3. энэ зүйлийн 14.2.1, 14.2.2-т зааснаас бусад тохио байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.

14.3.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага нь 1 заасан дүгнэлтийг үндэслэн гэрээг бүртгэхгүй байж болно.

14.4. Технологи дамжуулах гэрээг бүртгэлгүй тохиолдолд нологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ійн технологийг ашиглахыг хориглох талаар шийдвэр гаргана.

**15 дугаар зүйл**. Лицензийн төлбөр

15.1. Технологи ашиглахаар авч буй иргэн, аж ахуйн нэгж, гууллага тухайн технологи эзэмшигчид төлөх төлбөрийг ензийн төлбөр гэнэ.

15.2. Лицензийн төлбөр нь нэг удаагийн, эсхүл тухайн иологи ашигласнаас олох ашгийн тодорхой хувь хэмжээгээр гоосон байнгын шимтгэл, эсхүл эдгээрийг хосолсон хэлбэртэй ж болно.

15.3. Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч талууд ензийн төлбөрийн хэмжээ, хэлбэр, хугацааг гэрээгээр харилцан іролцоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

**І6 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх**

Монгол Улсын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн онд үүссэн технологи дамжуулахтай холбогдсон маргааныг Монгол ын олон улсын гэрээ, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр аагүй бол Монгол Улсын шүүх шийдвэрлэнэ.

**І7 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

17.1.Технологи дамжуулах тухай хууль тогтоомж зөрчсөний зас байгаль орчин, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан иргэн, аж ін нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн болон ргааны хариуцлага хүлээлгэж, түүгээр хохирлыг арилгуулах, нөхөн үлэх арга хэмжээ авна.

17.2. Технологийн нууцыг задруулсан иргэнийг 50000 хүртэл эгөөр, албан тушаалтныг 60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж уулагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэлийг шүүгч уулж, технологи эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх длыг шийдвэрлэнэ.

17.3. Технологийн түвшний үнэлгээ хийхэд шаардагдах баримт г, бусад зүйлийг бүрдүүлж өгөөгүй, эсхүл энэ хуулийн 14.1-д заасны у технологи дамжуулах гэрээг бүртгүүлээгүй иргэнийг 0 - 50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000 - 60000 төгрөгөөр, аж н нэгж, байгууллагыг 100000- 250000 төгрөгөөр торгох шийтгэлийг ч ногдуулна.

**18 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1998 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн да мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаат хот

## ЭМИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалт эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспорт түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харил зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Эмийн тухай хууль тогтоомж**

2.1.Эмийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1], Эр мэндийн тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамга тухай хууль[2], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан ху тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний зaal дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурд утгаар ойлгоно:

---

[1] Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дугээрт нийтлэгдсэн

[2] Малын удмын сан, эрүүл мэндийн тухай хууль "Ардын эрх" сонины 199 оны

4 дүгээр сарын 20-ны өдрийн 62, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 он 3 дугаарт тус тус нийтлэгдсэн.

3.1.1."эм" гэж хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, илох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалттай, үйлчлэл нь эм ил, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу эн, ургамал, эрдсийн гаралтай, тодорхой тун, хэмжээгээр лэгдлэг бодисыг;

3.1.2."биобэлдмэл" гэж хүний болон мал, амьтны өвчнийг эх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар амьд бие махбодь, түүний эд, эсээс үйлдвэрлэлийн онцгой нөхцөлд ж авсан бүтээгдэхүүнийг;

3.1.3."эмийн түүхий эд" гэж эм үйлдвэрлэх, найруулахад лэдэг, биологийн идэвхт бодис агуулсан цэвэр язгуур махбодь, эг болон ургамал, амьтан, эрдсийн гаралтай зүйлийг;

3.1.4."эмнэлгийн хэрэгсэл" гэж хүний болон мал, амьтны нийг оношлох, тэдгээрийг эмчлэх, сувилах, өвчнөөс урьдчилан йлэх зорилгоор бүтээгдсэн эмээс бусад зүйлийг;

3.1.5."эмийн улсын бүртгэл" гэж хими, биологи, эм судлал, н үнэлэмжийн үндсэн дээр эмчилгээ, оношлогоонд хэрэглэж к нь нотлогдсон эмийг хэрэглээнд гаргахыг зөвшөөрсөн алтыг;

3.1.6."эмийн үнэлэмж" гэж эмийн чанар, аюулгүй байдал, элийн идэвхийг эм зүй, эм судлал болон эмнэл зүйн гаагаар нарийвчлан тогтоосон илэрхийллийг;

3.1.7."зайлшгүй шаардлагатай эм болон эмнэлгийн хэрэгслийн алт" гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүрээнд логоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтэд эн тэргүүн лэхээр төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эм, эгийн хэрэгслийн нэрсийг;

3.1.8."фармакопей" гэж эмийг найруулах, бэлтгэх болон эмийн ыг шалгах аргыг заасан зайлшгүй мөрдөх стандартын түүврийг;

3.1.9."эм барих" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.17-д ыг;

3.1.10."хуурамч эм" гэж үйлчлэгч бодис, тун, найрлага, ыг дагалдах баримт бичигт нь заагдсанаас өөрчилсөн эмийг;

3.1.11."дууриамал эм" гэж эрх бүхий үйлдвэрийн эмийн сав, л, шошгыг ашиглаж хийсэн буюу тэдгээрийг адилтган хийж ган эмийг;

3.1.12."мансууруулах, сэтгэц нөлөөт эм" гэж донтуулах болон ийн бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, Олон улсын конвенцийн алтад заасан эм, биобэлдмэлийг;

3.1.13."цуврал" гэж тухайн эмийг нэг удаад багцлан эрлэсэн байдлыг заасан илэрхийллийг;

3.1.14."эмийн сан" гэж гэж эрүүл мэндийн байгууллага, мал эг, хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг

чанарын шаардлагын түвшинд явуулах, зохих зөвшөөрөл бү
мэргэжлийн байгууллагыг;

3.1.15."эмийн сангийн салбар" гэж жоргүйгээр олгох эм бо
эмнэлгийн хэрэгсэл худалдах зорилгоор эмийн сангаас байгуул
салбарыг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, эм хангамжийн тогтолцоо, эм барих үйл ажиллагаа

**4 дүгээр** зүйл.**Төрөөс эмийн талаар баримтлах бодлого**

4.1.Эмийн үндэсний бодлого нь Монгол Улсын үндэс
аюулгүй байдлыг хангах нэгдмэл бодлогын салшгүй хэсэг мөн.

4.2.Эмийн үндэсний бодлого нь эрүүл мэндийн байгуулл
мал эмнэлэг, хүн амыг өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, эм
улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслээр тасралт
хүртээмжтэй, жигд хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэ
чиглэнэ.

4.3.Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсл
жагсаалтыг хүний болон малын эрүүл мэндийн асуудал эрхэл
төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захирга
холбогдох төв байгууллага" гэх/ батална.

4.4.Эмийн үндэсний бодлого нь Засгийн газар, төр
захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын бодл
тусгагдаж, тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжин хэрэгжинэ.

**5 дугаар** зүйл.**Эмийн үндэсний зөвлөл**

5.1.Эмийн үндэсний зөвлөл нь эмийн үндэсний бодл
хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх орон тооны бус, мэргэжлийн, зө
байгууллага бөгөөд түүний бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн г
батална.

5.2.Эмийн үндэсний зөвлөл нь хүний болон малын эм
асуудал эрхэлсэн салбар зөвлөлтэй байж болно.

5.3.Эмийн үндэсний зөвлөл нь дараахь бүрэн эрх
хэрэгжүүлнэ:

5.3.1.эмийн үндэсний бодлогын асуудлаар санал, зөвл
боловсруулж, төрийн захиргааны холбогдох төв байгууллагад оруу

5.3.2.зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсл
жагсаалтад өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;

5.3.3.эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импорт
экспортлох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах;

5.3.4.мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жагсаа

эчлөх, хэрэглээнд хяналт тавих чиглэлээр мэргэжлийн зөвлөмж ргах;

5.3.5.эм, эмнэлгийн хэрэгслийн улсын стандарт, фармакопейн лтад мэргэжлийн дүгнэлт гаргах;

5.3.6.шинээр бүтээгдсэн эмэнд эм зүй, эм судлал, эмнэл зүйн шалгаа хийх зөвшөөрөл олгох, түүний дүнг хэлэлцэн, хэрэглэх эсэх ээр дүгнэлт гаргах.

**6 дугаар зүйл.Эм хангамжийн байгууллага**

6.1.Эм хангамжийн байгууллагад дараахь байгууллага хамаарна:

6.1.1.эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр;

6.1.2.эм ханган нийлүүлэх байгууллага;

6.1.3.эмийн сан, түүний салбар.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан эм хангамжийн байгууллагын эм, нэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, экспортлох, импортлоход шөөрөл авахаас бусад эм хангамжийн байгууллагатай холбогдсон илцаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12-21 дүгээр зүйлд снаар зохицуулагдана.

6.3.Хүн, малын эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох, портлоход зөвшөөрөл олгох, эм, эмнэлгийн хэрэгсэлд чанарын алгаажуулалт хийх үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу ийн захиргааны холбогдох төв байгууллага зохион байгуулна.

**7 дугаар зүйл.Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг**

7.1.Эм хангамжийн байгууллага нь үйл ажиллагаандаа эмийн мн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн эгслээр эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг жигд гах зарчмыг баримтална.

7.2.Эм хангамжийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай ийн 15 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараахь нийтлэг гийг хүлээнэ:

7.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хүний болон малын эмийг алах, нийлүүлэх;

7.2.2.эмийн хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг гасан нөхцөлд үйл ажиллагаа явуулах;

7.2.3.эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг йн талаархи мэдээллээр хангах, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, лүүлэлт, борлуулалтыг зохицуулах.

7.3.Эм ханган нийлүүлэх байгууллага нь эм, эмнэлгийн эгслийг эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, эмийн санд нөөр ханган нийлүүлнэ.

7.4.Эмийн сан, түүний салбар нь эм, эмнэлгийн хэрэгслийг үл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амд жижиглэн илдвална.

**8 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох, экспортлох**

8.1.Эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг импортлох, экспортлохыг зөвшөөрнө.

8.2.Эм импортлох, экспортлох зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох төв байгууллагаас баталсан журмын дагуу эм хангамжийг нийлүүлэх байгууллагад олгоно.

8.3.Зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр эм импортлох, экспортлохыг хориглоно.

8.4.Мэргэжлийн бус байгууллага, иргэн эмийг гадаадын тусламж, хандиваар авах тохиолдолд тэдгээр нь төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, уг эмийн чанарын баталгаажуулалт, хадгалалт, хэрэглээ, түгээлтийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

8.5.Эмнэлгийн хэрэгслийг импортлох, экспортлоход түүний бүтээсэн материалын бүтэц, чанар, тухайн хэрэгслийн техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна.

**9 дүгээр зүйл.Эмийг улсын хилээр нэвтрүүлэх**

9.1.Эмийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг Засгийн газар тогтооно.

9.2.Эм нэвтрүүлэхээр тогтоосон хилийн боомтоос бусад боомтоор эм нэвтрүүлэхийг хориглоно.

9.3.Зорчигчийн хувийн хэрэглээний эмэнд энэ зүйлийн заалт үл хамаарна.

**10 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх**

10.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэлийг төрийн захиргааны холбогдох төв байгууллагаас баталсан журмын дагуу зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ.

10.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд дараах үндсэн шаардлагыг хангасан байна:

10.2.1.улсын болон олон улсын стандартын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх технологи эзэмшсэн байх;

10.2.2.эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, үйлдвэрлэл явуулах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

10.2.3.үйлдвэрлэх бүтээгдэхүүн нь холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагаар чанарын баталгаажуулалт хийгдсэн, эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;

10.2.4.үйлдвэрлэлийн дамжлагыг технологийн дагуу удирдан хөтлөх, хянах мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх;

10.2.5.үйлдвэрлэлийн явцын болон эцсийн бүтээгдэхүүний анарын хяналтыг зохион байгуулах, чанарын баталгааг цуврал бүрт эргах мехнизмийг хангасан байх;

10.2.6.үйлдвэрлэсэн эмийн сав, баглаа, боодол, шошго нь тандартын шаардлага хангасан байх;

10.2.7.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь чанарын баталгаа хангасан айх;

10.2.8.эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэн гаргахдаа түүний үтээсэн материалын бүтэц, чанар, тухайн хэрэгслийн техникийн эдорхойлолтыг хавсаргасан байх;

10.2.9.металл, нийлэг материалаар бүтээсэн эмнэлгийн эрэгслийг хэрэглээнд гаргахын өмнө төрийн захиргааны холбогдох эв байгууллагаас томилогдсон мэргэжилтний хэсгийн дүгнэлт ргуулсан байх.

10.3.Хүчилтөрөгч, азотын дутуу исэл зэрэг эмчилгээний эриулалтын хийг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалахад тусгай журам римтална.

10.4.Энэ хуулийн 10.3-д заасан тусгай журмыг төрийн хиргааны холбогдох төв байгууллагууд хамтран батална.

**11 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд хориглох зүйл**

11.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд дараах йлийг хориглоно:

11.1.1.эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм болон эрх бүхий йгууллагаар чанарын баталгаажуулалт хийгдээгүй эмнэлгийн рэгсэл үйлдвэрлэх;

11.1.2.дууриамал болон хуурамч эм үйлдвэрлэх;

11.1.3.мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийг тусгай вшөөрөлгүй үйлдвэрлэх;

11.1.4.хүний зориулалттай эмийг мал, амьтны зориулалттай гтэй нэг шугам, дамжлага дээр үйлдвэрлэх;

11.1.5.чанарын баталгаагүй түүхий эд, материалаар эм, нэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх.

**12 дугаар зүйл.Эм барих үйл ажиллагаа явуулах**

Эрүүл мэндийн тухай хуулийн 22.3, 22.4-т заасан зөвшөөрөл хий хүн эм барих үйл ажиллагаа явуулна.

**13 дугаар зүйл.Эмийн сангийн үйл ажиллагаа**

13.1.Эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг эм, нэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг эмийн сан, түүний лбараар дамжуулан хэрэгжүүлнэ.

13.2.Эмчийн бичсэн жороор болон жоргүй олгох эмий жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тө байгууллагаас баталж мөрдүүлнэ.

13.3.Эмийн сангийн байршлыг оновчтой тогтоох, эм эмнэлгийн хэрэгслээр үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах үүргий нутгийн захиргааны байгууллага хүлээнэ.

13.4.Багийн хүн, малын эмч нь эмийн сан, түүний салбараа эм, эмнэлгийн хэрэгсэл авч, хүн амд үйлчилж болно.

**14 дүгээр зүйл.Эмийн сан, түүний салбарын үйл ажиллагаанд хориглох зүйл**

14.1.Эмийн сан, түүний салбарын үйл ажиллагаанд дараа зүйлийг хориглоно:

14.1.1.эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм болон чанара баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэх;

14.1.2.мал, амьтны зориулалттай эмийг хүнд хэрэглэхээр олго

14.1.3.жороор олгох эмийг жоргүйгээр олгох;

14.1.4.уламжлалт эмээс бусад эм, эмнэлгийн хэрэгслээр эмий сан, түүний салбараас өөр газарт үйлчлэх;

14.1.5.эм барих зөвшөөрөл аваагүй хүнээр эм бариулах;

14.1.6.нийтэд худалдаалахыг хориглосон эм, эмнэлгий хэрэгслээр үйлчлэх.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Эмийн улсын бүртгэл, эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт, эмийн мэдээлэл, сурталчилгаа

**15 дугаар зүйл.Эмийн улсын бүртгэл**

15.1.Эм үйлдвэрлэх, импортлох зөвшөөрөл бүхий байгууллагы үйлдвэрлэх, импортлох эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдс байна.

15.2.Эмийн улсын бүртгэлд эм бүртгүүлэх журмыг төрий захиргааны холбогдох төв байгууллага тогтоон мөрдүүлнэ.

15.3.Монгол Улсад хэрэглэх мансууруулах, сэтгэц нөле эмийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрий захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ.

**16 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт**

16.1.Монгол Улсад хүний болон мал эмнэлгийн зориулалта хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаажуулалты холбогдох хууль тогтоомжийн дагуу хийлгэсэн байна.

16.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг шалгаж галгаажуулахдаа улсын стандарт, фармакопей болон бусад рматив-техникийн баримт бичгийг үндэслэнэ.

16.3.Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, спортлох, нийлүүлэх, тээвэрлэх, түгээх, хэрэглэх болон мэдээлэх, этгээлчлах үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасны дагуу төрийн сиргааны холбогдох төв болон орон нутгийн байгууллага, ргэжлийн хяналтын алба хяналт тавина.

**17 дугаар зүйл.Эмийн талаархи мэдээлэл, сурталчилгаа**

17.1.Эмийн тухай мэдээлэл нь үнэн, зөв, бодитой бөгөөд лдвэрлэгч, ханган нийлүүлэгчээс хараат бус байна.

17.2.Эмийн тухай бодит мэдээллээр эрүүл мэндийн йгууллага, мал эмнэлэг, хүн амыг хангах ажлыг төрийн захиргааны лбогдох төв байгууллагын зөвшөөрснөөр мэргэжлийн байгууллага нон байгуулж хэрэгжүүлнэ.

17.3.Эмийн сурталчилгаанд дараахь зүйлийг хориглоно:

17.3.1.эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг импортлох, элүүлах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

17.3.2.жороор олгохоор заагдсан эмийг борлуулах зорилгоор ртлачлах;

17.3.3.мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг олон нийтийн дээллийн хэрэгслээр сурталчлах;

17.3.4.тухайн эмийн чанарыг өрөөсгөлөөр сурталчлах;

17.3.5.зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэхээр заагдсан эмийг ийн санд борлуулахаар сурталчлах.

**18 дугаар зүйл.Шинэ эм, эмнэлгийн хэрэгсэл бүтээх**

18.1.Монгол Улсад шинээр бүтээгдсэн эмийг бүртгэх, эмийн лэмж өгөх, эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг баталгаажуулах, шлэрлэх, хэрэглээнд гаргах зөвшөөрөл олгох журмыг холбогдох ль тогтоомжид нийцүүлэн төрийн захиргааны холбогдох төв йгууллага тогтоож мөрдүүлнэ.

18.2.Шинээр бүтээгдсэн эх орны болон анх удаа хэрэглэгдэх залын эмийг эмнэл зүйн судалгаа явуулан эмийн бүртгэлд ртгэгдсэний дараа хэрэглээнд гаргана.

18.3.Шинэ эм, эмнэлгийн хэрэгслийн патент, лиценз олгох удлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

18.4.Шинэ эм, эмнэлгийн хэрэгслийг хэрэглэхэд гаж нөлөө рвэл буруутай этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу иуцлага хүлээнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

**19 дүгээр зүйл.Эмийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

19.1.Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг импорта экспортлохтой холбоотойгоос бусад байдлаар эмийн тухай ху тогтоомж зөрчсөн тохиолдолд гэм буруутай этгээдэд эрүүги хариуцлага хүлээлгэхгүйгээр бол дараахь захиргааны шийтгэл хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон улсын байцаагч, шү ногдуулна:

19.1.1.энэ хуулийн 7.2.2-ыг зөрчсөн бол байгууллаг 100000-200000 төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах ба давтан үйлдвэл үйл ажиллагаа явуулах зөвшөөрлі хүчингүй болгох;

19.1.2.энэ хуулийн 8.1, 8.3-ыг зөрчсөн бол эм болон ху бусаар олсон орлогыг хураах, иргэнийг 30000-40000, ал тушаалтныг 40000-60000, байгууллага, аж ахуйн нэгж 150000-250000 төгрөгөөр торгох;

19.1.3.энэ хуулийн 8.4, 8.5-ыг зөрчсөн бол иргэні 10000-20000, албан тушаалтныг 20000-30000, байгууллага, аж ах нэгжийг 100000-150000 төгрөгөөр торгох;

19.1.4.энэ хуулийн 9.2-ыг зөрчсөн бол хууль бусаар ол орлогыг хураах, зөрчил гаргасан иргэнийг 25000-30000, ал тушаалтныг 40000-50000, байгууллага, аж ахуйн нэгж 150000-200000 төгрөгөөр торгох;

19.1.5.энэ хуулийн 10.1, 10.2, 11 дүгээр зүйлийн заалт зөрчсөн тохиолдолд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хураах ул орлого болгох буюу устгах, худалдсан тохиолдолд хууль бусаар ол орлогыг хураах улсын орлого болгох, зөрчил гаргасан байгуулла 150000-200000 төгрөгөөр торгох буюу эм, эмнэлгийн хэрэгсл үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг 6 сараас 1 жил, 6 сарын хугацаа хүчингүй болгох;

19.1.6.энэ хуулийн 14 дүгээр зүйлийн заалтыг зөрчсөн ал тушаалтныг 15000-20000, байгууллагыг 100000-150000 төгрө торгох ба давтан үйлдвэл эмийн сангийн үйл ажиллагаа яву зөвшөөрлийг 6 сараас 1 жилийн хугацаагаар хүчингүй болгох;

19.1.7.энэ хуулийн 17.3-ыг зөрчсөн иргэнийг 5000-20000, ал тушаалтныг 10000-25000, байгууллагыг 100000-150000 төгрө торгох.

19.2.Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг сургалч хэрэглэхтэй холбогдон илэрсэн зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн

нжтэй гэж үзвэл түүнийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад лжүүлнэ.

**20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж лөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

8 оны 5 дугаар ын 7-ны өдөр Улаанбаатар хот

## ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

! дугаар зүйл. Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт улах тухай хуулийн 2 дугаар зүйл дэх "3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн н улсын байгууллагатай" гэсний дараа "гадаадын хуулийн болон , этгээдтэй" гэснийг хассугай.

ИОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

8 оны 5 дугаар ын 7-ны өдөр Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

дугаар зүйл. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн й хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын дэд в, Байнгын хорооны дарга" гэсний дараа "Улсын Их Хурал дахь нам, ийн бүлгийн ахлагч нар" гэж нэмсүгэй.

ЮНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр — Улаанбаатар хот

### ХУУЛИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэв тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн:

"5. Өндөр насны тэтгэвэр авагч хөдөлмөрийн гэрээгээр ажилл байгаа бол түүний тогтоолгосон тэтгэврийг дор дурдсан хуви тооцож олгоно:

1/ тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ба бол 100 хувиар;

2/ тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс бол 60 хувиар;

3/ тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс бол 40 хувиар." гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 1998 оны 4 дүгээр сарын 1-ний өдре эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Р. ГОНЧИГДОР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1998 оны 5 дугаар сарын 15-ны өдөр — Улаанбаатар хот

### ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эдийн засаг, нийгм шаардлагатай үед дайны байдалд шилжүүлэх, цэргийн дайчилга бэлэн байдлыг хангах, дайчилгаа явуулах үндэслэл, журам, энэ талаа

жийн байгууллагын бүрэн эрх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн жийн удирдлага, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүргийг тоож, дайчилгаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад шино.

**2 дугаар зүйл. Дайчилгааны тухай хууль тогтоомж**

2.1.Дайчилгааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн гль, Дайны байдлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй йцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Дайчилгааны тухай хуулийн заалт Үндсэн хуулиас бусад хууль тоомжтой зөрчилдсөн тохиолдолд энэ хуулийг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр асан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

3.1.Энэ хуульд дурдсан нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

3.1.1."Бүх нийтийн дайчилгаа" гэж Монгол Улсын нийт нутаг эсгэрт дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөг бүрэн хэмжээгээр эгжүүлэхийг;

3.1.2."Хэсэгчилсэн дайчилгаа" гэж нутаг дэвсгэрийн зарим хэсэгт йчилгаа явуулах буюу хязгаарлагдмал зорилтыг хэрэгжүүлэхийн тулд йчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөний зөвхөн зарим арга хэмжээг эгжүүлэхийг;

3.1.3."Дайчилгааны сургалт" гэж төрийн удирдах албан тушаалтны гийн бэлтгэл, цэргийн үүрэгтэнтэй хуульд заасан хугацаанд явуулах эг, цэрэг-техникийн бэлтгэл, давтан бэлтгэлийг;

3.1.4."Дайчилгааны сургууль" гэж цэргийн хээрийн сургуульд чилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг татан оролцуулахыг;

3.1.5."Дайчилгааны даалгавар" гэж улс орны эдийн засаг, зэвсэгт нийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор энэ лийн 8 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан эрх бүхий гууллагаас төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, ахуйн нэгж, иргэдэд хүлээлгэсэн үүргийг;

3.1.6."Дайчилгааны нөөц" гэж зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг лдааны цагийн орон тоонд шилжүүлэхийн тулд дайчлан татахаар өвлөсөн төрийн болон төрийн бус байгууллага, иргэний өмчлөлд гаа зэвсэг, техник, эд хөрөнгийг;

3.1.7."Дайчилгааны бэлтгэл нөөцийн чөлөөт бүрэлдэхүүн" гэж эгт хүчний нэгтгэл,ангийг дайчилгааны даалгаврын дагуу нөхөн гасны дараа үлдэх цэргийн бэлтгэл үүрэгтэн иргэдийг;

3.1.8."Эд хөрөнгө" гэж зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг үүргээ эгтгэхэд шаардагдах хүнс, хувцас, шатахуун, тосолгооны материал, элгийн багаж хэрэгсэл, эм, ороох боох материал, техникийн сэлбэг, ад эд хогшлыг;

3.1.9."Баталгаат албан тушаал" гэж улс орны удирдлага, эдийн эг, нийгмийн үндсэн салбаруудын тогтвортой ажиллагааг хангахын а цэргийн дайчилгаанаас чөлөөлж байхаар Засгийн газраас

тогтоосон албан тушаалыг;

3.1.10."Цугларах байр" гэж дайчилгааны бэлтгэл нөөци бүрэлдэхүүнийг дайчлах ажлыг зохион байгуулахаар сонгож авсан бай байршил, газрыг;

3.1.11."Шилжүүлэх байр" гэж техник, хэрэгслийг дайчлан тат ажлыг зохион байгуулахаар сонгож авсан байр, байршил, газрыг;

3.1.12."Улсын захиалга-даалгавар" гэж батлан хамгаал хэрэгцээг хангахын тулд Засгийн газраас байгууллага, аж ахуйн нэгж тогтоож өгөх заавал биелүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төлөвлөгөөг;

3.1.13."Дайчилгааны төлөвлөгөө" гэж улс орны эдийн заса нийгэм, зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэхийн тулд хэрэгжүүл арга хэмжээг цаг хугацаа, байр, үүрэг, хариуцах эзэн, арга хэлбэ багтаамжаар нь уялдуулан зохицуулж урьдчилан боловсруулс цогцолбор баримт бичгийг тус тус хэлнэ.

**4 дүгээр зүйл. Дайчилгаа**

4.1.Дайчилгаа нь улс орны эдийн засаг, нийгмийг дайны байда шилжүүлэх, зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор нөх хангахын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгаа болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төр, төрі захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хуулийн дагуу а хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

4.2.Дайчилгаа нь бүх нийтийн буюу хэсэгчилсэн байна.

**5 дугаар зүйл. Дайчилгааны зарчим**

Дайчилгаа дараах зарчимд тулгуурлана:

5.1.1. төвлөрүүлэн удирдах;

5.1.2. урьдчилан төлөвлөгдсөн байх;

5.1.3. цаг үеэ олсон байх;

5.1.4. байнга зохицуулагдаж байх.

**6 дугаар зүйл. Дайчилгаа зарлах**

6.1.Дайчилгааг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дүгнэлти үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч зарлана.

6.2.Дайчилгаа зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчи зарлигт дараах асуудлыг тусгана:

6.2.1. дайчилгаа зарлахад хүргэсэн цэрэг-улс төрийн нөхц байдал;

6.2.2. дайчилгаа явуулах нутаг дэвсгэр;

6.2.3. дайчлах хүний тоо, насны хязгаар, цэргийн мэргэжли ангилал;

6.2.4. дайчлах эд хөрөнгийн төрөл, тоо хэмжээ;

6.2.5. дайчилгаа эхлэх хугацаа /он, сар, өдөр, цаг/, явуул дараалал;

6.2.6. дайчилгаа зохион байгуулж явуулах журам;

6.2.7. хуульд нийцсэн шаардлагатай бусад заалт.

6.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн дайчилгаа зарласан зарлиг хүчин төгөлдөр болсон даруй хэрэгжүүлж эхэлнэ.

6.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн дайчилгаа зарласан зарлиг гаснаас хойш Улсын Их Хурал түүнийг нэн даруй чуулганаараа хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал дайчилгаа зарлах шаардлагагүй гэж үзвэл Ерөнхийлөгчийн зарлиг хүчингүй болно.

6.5.Дайчилгаа зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал хүчингүй болгосон тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага болон бүх шатны Засаг дарга нар дайчилгааг нэн даруй зогсоох арга хэмжээ авч, гүйцэтгэлд нь хяналт тавина.

### 7 дугаар зүйл. Дайчилгааны зарлан мэдээлэл

7.1.Дайчилгааны зарлан мэдээллийг Зэвсэгт хүчний ерөнхий штаб зохион байгуулна.

7.2.Дайчилгааны зарлан мэдээллийн тогтолцоог тайван цагт бүрдүүлж, байнгын бэлэн байдалд байлгана.

7.3.Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журмыг Засгийн газар тогтооно.

### 8 дугаар зүйл. Дайчилгааны даалгаврыг тогтоох

8.1.Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дайчилгааны даалгавартай байна.

8.2.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг Засгийн газар, сум, дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус тогтооно.

8.3.Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг байлдааны цагийн орон тооны дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах даалгаврыг Зэвсэгт хүчний ерөнхий штаб тогтооно.

### 9 дүгээр зүйл. Дайчилгааны төлөвлөлт

9.1.Монгол Улс дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөтэй байна.

9.2.Дайчилгааны даалгавар бүхий төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг болон дайчилгааны даалгавар бүхий байгууллага, аж ахуйн нэгж тус бүр дайчилгааны төлөвлөгөөтэй байна.

9.3.Дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг Засгийн газар; сум, дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус батална.

9.4.Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг дайчилгаагаар нөхөн хангах төлөвлөгөөг Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга батална.

### 10 дугаар зүйл. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн

10.1.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн нь цэргийн нөөц болон бэлтгэл албанд тэнцэх насны иргэдээс бүрдэнэ.

10.2.Нисэх онгоц, нисдэг тэрэг, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, автомашин, мотоцикл, өөрөө явагч машин механизм болон Зэвсэгт хүчний хэрэгцээнд шилжүүлэхээр дайчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан

эд хөрөнгийг өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр дайчилгааны нөөцө
бүртгэнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Дайчилгааны талаархи Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

**11 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

11.1.Монгол Улсын Их Хурал тайван цагт дайчилгааны талаа дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. Монгол Улсын зэвсэгт хүчний дайчилгааны бэлэн байдал нөөцийн бүрдүүлэлтийн дүнгийн талаар Засгийн газрын илтгэлийг жи тутам сонсож дүгнэлт гаргах;

11.1.2. дайчилгааны бэлтгэлийг хангах, нөөцийг бүрдүүлэ хөрөнгийг улсын нэгдсэн төсөвт тусган батлаж, зарцуулалтад хянаг тавих.

11.2.Монгол Улсын Их Хурал дайчилгаа зарласан үед дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1. дайчилгаа зарлах буюу дайчилгаа зарласан тухай Монго Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй авч хэлэлцэн батлах буюу хүчингүй болгох шийдвэр гаргах;

11.2.2. Монгол Улсын хууль тогтоомжид дайчилгаа зарласа нөхцөл байдалтай зохицуулан нэмэлт, өөрчлөлт оруулах;

11.2.3. дайчилгааны явцад хяналт тавих.

11.3.Монгол Улсын Их Хурал хуульд заасан бусад бүрэн эрхий хэрэгжүүлнэ.

**12 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх**

12.1.Монгол Улсын Ерөнхийлөгч тайван цагт дайчилгааны тала дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. Зэвсэгт хүчний ерөнхий штабын дайчилгааны төлөвлөгө батлах;

12.1.2. зэвсэгт хүчний дайчилгааны нөөцийн бүрдүүлэлтэд хянал тавих, энэ талаар Засгийн газарт чиглэл өгөх;

12.1.3. төрийн байгууллагын удирдах албан тушаалтны цэргий бэлтгэл, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний бүртгэл, давта бэлтгэл, сургалтын байдалд хяналт тавих.

12.2.Монгол Улсын Ерөнхийлөгч дайчилгаа зарласан үед дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1. бүх нийтийн буюу хэсэгчилсэн дайчилгаа зарлах тухай шийдвэр гаргах;

Монгол Улсын Ерөнхийлөгч дайчилгаа зарласан тухай зарлиг Улсын Их Хурлын даргад нэн даруй өргөн мэдүүлнэ.

12.2.2. Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, холбогдох бусад бан тушаалтны илтгэлийг сонсож, чиглэл, үүрэг даалгавар өгөх;

12.2.3. цэргийн албанд татах бэлтгэл офицер, дайчилгааны лтгэл нөөцийн бүрэлдэхүүний насны дээд, доод хязгаарыг шинэчлэн гтоох, байлдагч түрүүчийн цэргийн алба хаах хугацааг сунгах тухай йдвэр гаргах.

12.3.Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бусад бүрэн эрхийг рэгжүүлнэ.

**13 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

13.1.Монгол Улсын Засгийн газар тайван цагт дайчилгааны талаар раахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг хянан батлах;

13.1.2. төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн йчилгааны даалгаврыг тогтоох;

13.1.3. төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн йчилгааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж, лбогдох албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонсох;

13.1.4. дайчилгааны нөөцийг бүрдүүлэх журам, тэдгээрийн мжээ, байршлыг тогтоох;

13.1.5. дайчилгаа зарласан үед үүрэг зориулалтыг нь өөрчлөн ргийн зориулалтаар ашиглах байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гсаалтыг батлах;

13.1.6. үйлдвэр, аж ахуйн нэгжид ногдуулах улсын захиалга-алгаврыг тогтоох;

13.1.7. баталгаат албан тушаалын жагсаалт батлах;

13.1.8. хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн иийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор төлөх журмыг тогтоох.

13.2.Монгол Улсын Засгийн газар дайчилгаа зарласан үед раахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.2.1. дайчилгаа зарласан тухай Ерөнхийлөгчийн зарлигийг эгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.2.2. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагад эгжүүлж байгаа дайчилгааны арга хэмжээ нь хууль тогтоомж, йчилгааны төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

13.2.3. улсын төвлөрсөн төсөвт зохицуулалт хийж, дайчилгааны га хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх санал боловсруулж сын Их Хуралд өргөн мэдүүлэх.

13.2.4. гадаад, дотоод худалдаанд онцгой байдал тогтоож, териаллаг хэрэглэлийн хуваарилалтын нормчлолыг батлах;

13.2.5. улсын нөөцийг захиран зарцуулах, цэргийн дайчилгааны ацийг захиран зарцуулах эрхийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн сгийн газрын гишүүнд олгох.

13.3.Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бусад бүрэн ийг хэрэгжүүлнэ.

**14 дүгээр зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

14.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүү тайван цагт дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуула журам тогтоож, удирдамж гаргах;

14.1.2. аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгжий дайчилгааны бэлэн байдлыг шалгах, холбогдох мэдээ, судалгаа гаргуулан авах;

14.1.3. дайчилгааны бэлтгэлийг хангах төсвийн төслийг Засгий газарт оруулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах.

14.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүү дайчилгаа зарласан үед дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.2.1. дайчилгаа зарласан тухай Ерөнхийлөгчийн зарлигий хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

14.2.2. төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлий дайчилгааны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилтийн явцад хянал тавих;

14.2.3. цэргийн дайчилгааны нөөцийг захиран зарцуулах;

14.2.4.дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Монго Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар мэдээлэх;

14.2.5.дайчилгааны явцад бий болсон урьдчилан төлөвлөгдөөгү асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлэх, биелэлтэд хяналт тавих.

14.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүү хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.4.Цэргийн дайчилгаа зарласан үеэс эхлэн батлан хамгаала асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Зэвсэгт хүчний Ерөнхи командлагчийн орлогчийн албан тушаалд орж, түүний бүрэн эрхий хэрэгжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

**Дайчилгааны талаархи төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үүрэг**

**15 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг**

15.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны тө байгууллага тайван цагт дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1. дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөө болон төрий захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгаан двалгаврын төслийг боловсруулж Засгийн газарт оруулах;

15.1.2. дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд нь ийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт эгэжлийн туслалцаа үзүүлэх;

15.1.3. Монгол Улсын дайчилгааны нөөцийн талаарх нэгдсэн щоог хөтлөх;

15.1.4. зэвсэгт хүчнийг зэвсэг, цэргийн техник, бусад материал, ōгслоор хангах, нөхөн хангах санал төлөвлөж Засгийн газарт оруулах;

15.1.5. төрийн захиргааны төв байгууллагын дайчилгааны өвлөгөөний төслийг хянах, дүгнэлт гаргах;

15.1.6. төрийн удирдах албан тушаалтны дайчилгааны сургалтыг ион байгуулах;

15.1.7. энэ хууль, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн йдвэрийн гүйцэтгэлийг зохион байгуулах.

15.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв гууллага дайчилгаа зарласан үед дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1. дайчилгаа зарласан тухай Ерөнхийлөгчийн зарлигийг эгжүүлэх ажлыг зохион байгуулах;

15.2.2. дайчилгааны явцыг төрийн захиргааны төв, нутгийн иргааны байгууллага, байгууллага, аж ахуйн нэгжид шалгаж туслах;

15.2.3. дайчилгааны явцын талаарх нэгдсэн мэдээ гаргаж, Улсын Хурал, Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын хороо, Засгийн арт илтгэх.

15.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв гууллага хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**16 дугаар зүйл. Төрийн захиргааны бусад төв байгууллагын үүрэг**

16.1.Төрийн захиргааны бусад төв байгууллага тайван цагт аахь үүрэг хүлээнэ:

16.1.1.дайчилгааны даалгаврыг үндэслэн өөрийн үндсэн үүргийн ээн дэх дайчилгааны төлөвлөгөөний төслийг боловсруулан батлан гаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын алыг тусган Засгийн газарт оруулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

16.1.2. харъяа байгууллага,салбарын дайчилгааны даалгаврыг оох, тэдний дайчилгааны төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт их;

16.1.3. дайчилгааны даалгаврын дагуу эд хөрөнгийн нөөцийг зүүлэх, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах;

16.1.4. үндсэн чиг үүргийнхээ дагуу дайчилгааны бэлтгэл алтыг зохион байгуулж явуулах;

16.1.5. харъяа байгууллага, салбарын дайчилгааны бэлэн длыг хангах ажлыг зохион байгуулах;

16.1.6. цэргийн дайчилгааны бэлэн байдлын мэдээг жил тутам аж батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв уулагад өгөх;

16.1.7. аймаг,нийслэлийн дайчилгааны бэлтгэлийг хангахад рдагдах төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих.

16.2.Төрийн захиргааны бусад төв байгууллага дайчилга зарласан үед дараахь үүргийг хүлээнэ:

16.2.1. дайчилгааны төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэ нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны нөөцийг дайчлан татаж зэвсэг хүчинд шилжүүлэх;

16.2.2. харъяа байгууллага, салбарын үйл ажиллагааг дайчилга зарласан нөхцөл байдалд шилжүүлэх;

16.2.3. дайчилгааны нөөцийг нөхөн бүрдүүлж, түүний бэлэ байдлыг хангах.

16.3.Төрийн захиргааны бусад төв байгууллагууд хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.

**17 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үүрэг**

17.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдий Хурал дараахь үүрэг хүлээнэ:

17.1.1. аймаг, нийслэл, сум, дүүргийн дайчилгааны даалгавры хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын мэдээлэл сонсо чиглэл өгөх;

17.1.2. дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх шаардагдах төсөв, хөрөнгийг хуваарилж, зарцуулалтад хяналт тавих.

17.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдий Хурал хуульд заасан бусад үүргийг хүлээнэ.

**18 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын үүрэг**

18.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь үүрэг хүлээнэ:

18.1.1. дайчилгааны даалгаврыг үндэслэн аймаг, нийслэлий дайчилгааны төлөвлөгөөг Засгийн газраар; зэвсэгт хүчний нэгтгэл, анги бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах дайчилгааны төлөвлөгө Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргаар тус тус батлуулан хэрэгжүүл ажлыг зохион байгуулах;

18.1.2. сум, дүүргийн дайчилгааны даалгаврыг тогтоож, тэдни дайчилгааны төлөвлөгөөг батлах;

18.1.3. дайчилгааны бэлтгэлийг хангах төсвийн төсли боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, батлагдс төсвийг захиран зарцуулах;

18.1.4. дайчилгааны даалгавраар тогтоогдсон материа хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх ажл зохион байгуулах;

18.1.5. нутаг дэвсгэртээ дайчилгааны зарлан мэдээлэл явуул журмыг тогтоож бэлэн байдлыг хангах;

18.1.6. дайчилгаа зарласан үед дайчилгааны даалгавр тогтоосон хугацаанд нь биелүүлэх;

18.1.7. дайчилгааны арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүл нөхцөлийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

18.1.8. цугларах, шилжүүлэх байрыг тогтоох.

18.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга хууль тогтоомжид заасан сад үүргийг хүлээнэ.

**19 дүгээр зүйл. Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг даргын үүрэг**

19.1.Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг дарга дараахь үүрэг лээнэ:

19.1.1. нутаг дэвсгэртээ дайчилгааны зарлан мэдээлэлт явуулах питгэл, бэлэн байдлыг хангах;

19.1.2.сум, дүүрэг /баг, хороо/-ийн дайчилгааны төлөвлөгөөний элийг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан рдөн ажиллах;

19.1.3. нутаг дэвсгэртээ байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн йчилгааны даалгаврын биелэлтэд хяналт тавих;

19.1.4.дайчилгаа зарласан үед дайчилгааны даалгаврыг тогтоосон гацаанд нь биелүүлэх.

19.2.Сум, дүүрэг /баг, хороо/-ийн Засаг дарга хууль тогтоомжид асан бусад үүрэг хүлээнэ.

**20 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг**

20.1.Байгууллага, аж ахуйн нэгж дараахь үүрэг хүлээнэ:

20.1.1. дайчилгааны даалгаврыг биелүүлэх;

20.1.2. дайчилгааны эд хөрөнгийн нөөцийг тогтоосон хугацаанд йлүүлэх, бэлэн байдлыг хангах;

20.1.3.улсын захиалга-даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлэх.

20.2.Байгууллага, аж ахуйн нэгж хууль тогтоомжид заасан бусад үгийг хүлээнэ.

**21 дүгээр зүйл. Иргэний үүрэг**

21.1.Монгол Улсын иргэн дараахь үүрэг хүлээнэ:

21.1.1. дайчлан татах үед тогтоосон хугацаанд, заасан газарт эх;

21.1.2. хуульд заасны дагуу сургалт, дайчилгаатай сургууль, ларалтад оролцох;

21.1.3. дайчилгааны даалгаврын дагуу эд хөрөнгийг нийлүүлэх.

21.2.Монгол Улсын иргэнд дайчилгааны бусад үүргийг хуулиар ээлгэж болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## Дайчилгаа явуулах

**22 дугаар зүйл. Дайчилгаа явуулах үндэслэл**

22.1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад заас аюул занал учруулж зэвсэглэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь зитой болсон үед дайчилгаа явуулна.

22.2.Дайчилгаатай сургуульд оролцуулахын тулд түр хугацаагаар йчилгааны нөөцийн зарим хэсгийг ашиглуулж болно.

**23 дугаар зүйл. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг дайчлах**

23.1.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээри дайчлах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

23.2.Дайчилгаагаар эхний ээлжинд дайчлагдах дайчилгаа бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо, тэдгээрт цэрэгт бүртгэгдс мэргэжлийн дугаарыг энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасн дагуу тогтооно.

23.3.Цэргийн бэлтгэл үүрэгтэн нь дайчилгаа зарламагц дайчл хуудсанд заасан хугацаанд цугларах байранд ирэх үүрэгтэй.

23.4.Цэргийн бэлтгэл үүрэгтэн тогтоосон хугацаанд цуглар байранд ирээгүй тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарг захирамжаар түүнийг дайчилгааны бэлтгэл нөөцийн чөлө бүрэлдэхүүнээс нөхөн солино. Тогтоосон хугацаанд цугларах байра ирээгүй цэргийн бэлтгэл үүрэгтэнд энэ хуулийн 36 дугаар зүйлийн 2 да хэсэгт заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.5.Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч дайчилг зарласан үед дайчлагдан татагдах цэргийн бэлтгэл үүрэгтэнг аж сургуулиас чөлөөлөх, албан томилолт, амралттай явсан бол яаралт дуудаж тогтоосон хугацаанд нь цугларах байранд ирүүлэх үүрэгтэй.

23.6.Цэргийн бэлтгэл үүрэгтэнг дайчлан алба хаах цэргийн ан болон үүрэг гүйцэтгэх газарт нь хүргэхэд шаардагдах тээвэр, хү байрны зардлыг аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллa хариуцна.

23.7.Гадаадад оршин суугаа цэргийн бэлтгэл үүрэгтэнг дайчл ажлыг батлан хамгаалах болон гадаад харилцааны асуудал эрхэлс төрийн захиргааны төв байгууллага хамтран гүйцэтгэнэ.

**24 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг дайчлах**

24.1.Төрийн болон төрийн өмч давамгайлсан агаарын тээври байгууллагыг цэргийн зохион байгуулалтад оруулж, зэвсэгт хүчн бүрэлдэхүүнд шилжүүлнэ.

24.2.Хувийн өмчийн агаарын тээврийн байгууллагын нис хэрэгсэл, аэродром, техникийн хангалтын тоног төхөөрөмжийг төрө нөхөх олговортойгоор дайчилна.

24.3.Төмөр зам, усан замын тээврийн байгууллагыг цэрэгжүүлс зохион байгуулалтад оруулж, хөдлөх бүрэлдэхүүн, зам ашиглалт төвлөрсөн удирдлагыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төри захиргааны төв байгууллагад шилжүүлнэ.

24.4.Төрийн өмчийн авто тээврийн хэрэгсэл, механизмыг зэвс хүчний байлдааны цагийн орон тооны нөхөн хангалтад дайчл шилжүүлнэ.

24.5.Хувийн өмчийн автомашин, мотоцикл, өөрөө явагч маш механизм зэрэг тээврийн хэрэгслийг нөхөн олговортойгоор зэвс хүчний нөхөн хангалтад шилжүүлнэ.

24.6.Хувийн өмчийн агт морь, бусад ажлын мал, ердийн хөсгийг

ог хэрэглэлийг дайчилгааны даалгаврын дагуу нехех олговортойгоор ичилна. Жишиг үнийг тухайн үеийн ханшийг харгалзаж Засгийн газар тооно.

24.7.Дайчлагдсан тээврийн хэрэгслийг цэргийн анги, ашиглах эрт нь хүргэхэд шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн төрийн иргааны байгууллага хариуцна.

**25 дугаар зүйл. Эд хөрөнгийг дайчлах**

25.1.Зэвсэгт хүчний хэрэгцээт эд хөрөнгийг дайчилгааны илгаврын дагуу төрийн захиргааны төв, нутгийн захиргааны гуулага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд оногдуулан дайчилна.

25.2.Төрийн өмч даваамгайлсан байгууллага, аж ахуйн нэгжийн эд өнгийг захиран зарцуулах эрх дайчилгаа зарласан тухай Монгол ын Ерөнхийлөгчийн зарлиг гармагц төр, түүний эрх бүхий гуулагад төвлөрнө.

25.3.Төрийн бус байгууллага, хувийн өмчийн эд хөрөнгийг нөхөх говортойгоор дайчилна.

25.4.Эд хөрөнгийг дайчлах, цэргийн ангид тээвэрлэж хүргэхэд рдагдах зардлыг аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллага иуцна.

**26 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг дайчлах**

26.1.Дайчилгаа зарлангуц төрийн өмчийн байгууллага, аж ахуйн кийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах, захиран цуулах эрхийг төр, түүний эрх бүхий байгууллагын мэдэлд перүүлнэ.

26.2.Хувийн өмчийн газар, барилга байгууламж, үйлдвэрлэлийн ог төхөөрөмжийг зэвсэгт хүчний зайлшгүй хэрэгцээнд дараах маар дайчилна:

26.2.1. нөхөн олговортойгоор зэвсэгт хүчний хэрэгцээнд бүрмөсөн ткүүлэх;

26.2.2. өмчлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр ашиглалтын хөлсийг к ашиглах.

26.3.Хувийн өмчийн аж ахуйн нэгжийн зориулалтыг улсын иалга-даалгавраар өөрчилж болно.

26.4.Улсын захиалга-даалгавар хүлээсэн хувийн өмчийн гуулага, аж ахуйн нэгж түүнийг заавал биелүүлэх үүрэгтэй.

**27 дугаар зүйл. Галт зэвсгийг дайчлах**

Хувийн өмчид байгаа бүх төрлийн галт зэвсэг, сум хэрэглэлийг гийн дайчилгааны даалгаврын дагуу аймаг, нийслэлийн төрийн иргааны байгууллага дайчлан цэргийн хэрэгцээнд шилжүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ

**Дайчилгааны сургалт**

**28 дугаар зүйл. Төрийн захиргааны ажилтны цэргийн бэлтгэл**

28.1.Төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтн цэргийн бэлтгэл нь дараахь тогтолцоонсоос бүрдэнэ:

28.1.1. яамны төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлий Засаг дарга, Тамгын газрын дарга нарын цэрэг-стратегийн бэлтгэ сургалт 4 жилд нэг удаа 7 хоног;

28.1.2. сум, дүүргийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалт жилд нэг удаа 3 хоног;

28.1.3. баг, хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургал жилд нэг удаа 3 хоног:

28.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэрээр улс төрийн албе тушаалтнуудыг цэрэг-стратегийн бэлтгэл сургалтад хамааруулна.

28.3.Тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн захирал, байгууллаг аж ахуйн нэгжийн удирдах ажилтан нарын цэргийн бэлтгэл сургалты хугацаа, үечлэл, оролцуулах бүрэлдэхүүнийг Засгийн газар тогтооно.

**29 дүгээр зүйл. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт**

29.1.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалты дараахь журмаар явуулна:

29.1.1. бэлтгэл офицеруудын сургалтыг 5 жилд нэг удаа, аймa нийслэлд 1 сар;

29.1.2. цэргийн чухал мэргэжил бүхий нэгдүгээр зэргийн бэлтгэ үүрэгтний сургалтыг 3 жилд 1 удаа цэргийн анги байгууллагад 1 сар;

29.1.3. нэгдүгээр цэргийн бусад бэлтгэл үүрэгтний сургалтыг жилд нэг удаа аймаг, нийслэлд 1 сар;

29.1.4. хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг бэлтгэл байх хугацаанд нь аймаг, нийслэлд 3 сар.

29.2.Сургалт явуулахад шаардагдах зардлыг жил бүрийн улсы төвлөрсөн ба орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

**30 дугаар зүйл. Дайчилгаатай сургууль явуулах**

30.1.Дайчилгаатай сургууль явуулах журам, хугацаа, түүн оролцуулах дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоог Засгий газар тогтооно.

30.2.Дайчилгаатай сургууль явуулах зардлыг батлан хамгаал арга хэмжээний төсвөөс санхүүжүүлнэ.

**31 дүгээр зүйл. Цэргийн бэлтгэл үүрэгтэнг дайчилгаатай сургуульд оролцуулах**

31.1.Дайчилгаатай сургуульд оролцуулах цэргийн бэлтгэ үүрэгтний тоог Зэвсэгт хүчний ерөнхий штаб цэрэгт бүртгэлд мэргэжлийн дугаараар нь гаргаж уг цугларалт, сургууль явуулахаас н жилийн өмнө аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.

31.2.Дайчилгаатай сургуульд оролцох иргэнд аймаг, нийслэлийн ıсаг даргын Тамгын газрын цэрэг-иргэний хамгаалалтын штаб, тларалт сургууль эхлэхээс 1 сарын өмнө дайчлан татах хуудсыг рдуулна.

31.3.Дайчилгааны бэлэн байдлыг шалгах зорилгоор цэргийн гтгэл, ангийг байлдааны цагийн орон тоонд ногдуулан данслагдсан ргийн бэлтгэл үүрэгтнийг дайчлан татах хуудас урьдчилан рдуулахгүйгээр дайчилгааны дохиогоор цуглуулан сургуульд олцуулж болно.

31.4.Цэргийн бэлтгэл үүрэгтнийг дайчилгаатай сургууль оролцох гацаанд түүний эрхэлж байсан ажлын байрыг үндсэн байгууллага нь вээр хадгалж, сүүлийн 3 сарын дунджаар тооцон цалин хөлсийг гоно. Цэргийн бэлтгэл үүрэгтэн тэтгэвэр авдаг бол түүнийг хэвээр гоно.

Бэлтгэл офицер, цэргийн бэлтгэл үүрэгтэнд цалин олгох хэмжээ, рмыг Засгийн газар тогтооно.

31.5.Дайчилгаатай сургуульд оролцогчдод байлдагч, түрүүчийн рмоор хүнс, орон сууц, эмнэлэг, соёл, ахуй үйлчилгээний хангалт лүүлнэ. 30 хоногоос дээш хугацаагаар сургуульд оролцох тохиолдолд ирлын цэргийн дүрэмт хувцсаар түр хангана.

31.6.Дайчилгааны сургалт, сургуульд оролцсон цэргийн бэлтгэл эгтний иргэний паспортод энэ тухай тэмдэглэл хийнэ.

**32 дугаар зүйл.** Техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд дайчлан оролцуулах

32.1.Зэвсэгт хүчний ерөнхий штабын төлөвлөгөөгөөр нисэх онгоц, сдэг тэрэг, тээврийн болон тусгай зориулалтын авто техник, мотоцикл, рөө явагч механизм, бусад техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд олцуулж болно.

32.2.Нисэх онгоц, нисдэг тэрэг, тээврийн болон тусгай эиулалтын авто техник, мотоцикл, өөрөө явагч механизм, бусад техник рэгслийг хариуцсан хүнд нь эзэмшүүлэн дайчилна.

32.3.Хэрэв хариуцсан эзэмшигч нь өндөр настай буюу хүндэтгэн ıх бусад шалтгаантай бол эзэмшигч өмчлөгчтэй нь зөвшөөрөлцсөний ідсэн дээр бусдад эзэмшүүлэн дайчилгаатай сургуульд оролцуулж лно.

32.4.Дайчилгаатай сургуульд татан оролцуулж байгаа нисэх онгоц, сдэг тэрэг, тээврийн болон тусгай зориулалтын автотехник, мотоцикл, эөө явагч механизм, бусад техник хэрэгслийг сургуульд оролцох ацаанд шатахуун, тосолгооны материалаар хангах, тэдгээрийн иглаптын зардлыг тогтоосон журмаар төлөх асуудлыг Зэвсэгт хүчний энхий штаб хариуцна.

32.5.Техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд оролцуулсаны лсийг төлөх журмыг Засгийн газар тогтооно.

32.6.Дайчлан татсан техник хэрэгсэл сургуулийн явцад гэмтэж, эрсэн нь эзэмшигчийн буруу биш бол хохирлыг Зэвсэгт хүчний энхий штаб төлнө.

32.7.Сургалт, дайчилгаатай сургуулийн үед дайчлан татсан техн хэрэгслийг цэргийн анги, үүрэг гүйцэтгэх газарт хүргэх зардлыг аймаг нийслэлийн төрийн захиргааны байгууллага, буцаах зардлыг Зэвсэ хүчний ерөнхий штаб хариуцна.

**33 дугаар зүйл. Дайчилгааны даалгавартай байгууллага, аж ахуйн нэгжтэй дайчилгааны сургууль явуулах**

33.1.Дайчилгааны даалгавартай байгууллага, аж ахуйн нэгжи бэлэн байдлыг шалгах, дайчилгааны даалгавар хэрэгжүүлэх дадлаг эзэмшүүлэх зорилгоор батлан хамгаалах асуудал эрхэлсэн төри захиргааны төв байгууллагын төлөвлөгөөгөөр дайчилгааны сургуу явуулна.

33.2.Байгууллага, аж ахуйн нэгжтэй явуулах дайчилгаат сургуулийн зардлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төри захиргааны төв байгууллага хариуцна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

## Бусад зүйл

**34 дүгээр зүйл. Дайчилгааны арга хэмжээний нууцлалт**

34.1.Цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх ар хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр нь төрийн нууц мөн.

34.2.Дайчилгааны нууцын зэргийг хууль тогтоомжоор тогтооно.

34.3.Зарлан мэдээлэхээс бусад цэргийн дайчилгаатай холбогдо мэдээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуул сурталчлахыг хориглоно.

**35 дугаар зүйл. Дайчилгааны арга хэмжээний санхүүжилт**

35.1.Дайчилгааны арга хэмжээг улсын төвлөрсөн болон ор нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

35.2.Дайчилгааны арга хэмжээг санхүүжүүлэхийн тулд хуви хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн нөөцийг төр, төри захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага нөхөх олговортойго дайчилж болно.

35.3.Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилс санхүүгийн нөөцийг буцаан төлөх журмыг Засгийн газар тогтооно.

**36 дугаар зүйл. Дайчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

36.1.Дайчилгааны тухай хууль тогтоомж зөрчигчид Монгол Улс хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн болон захиргааны хариуцла хүлээлгэнэ.

36.2.Энэ хуулийн 20 дугаар зүйл, 23.4-т заасан нөхцө дайчилгааны хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцла хүлээлгэнэ.

36.3.Дайчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн иуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл дуулна:

36.3.1.энэ хуулийн 6.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 000-200000 төгрөгөөр торгох;

36.3.2.энэ хуулийн 21.1.2-т заасныг зөрчсөн этгээдийг 00-100000 төгрөгөөр торгох;

36.3.3.энэ хуулийн 21.1.1, 21.1.3-т заасан журам зөрчсөн этгээдийг үгийн хариуцлагад татахааргүй байвал 300000-500000 төгрөгөөр гох.

36.4.Энэ хуулийн 36.3.1-д заасан шийтгэлийг төрийн захиргааны байгууллагын эрх бариуч, аймаг, нийслэлийн Засаг даргад шүүх, ад Засаг дарга нарт дээд шатны Засаг дарга, 36.3.2-т заасан йтгэлийг шүүх, 36.3.3-т заасан шийтгэлийг аймаг, нийслэлийн Засаг га тус тус ногдуулна.

36.5.Дайны байдлын үед дайчилгааны тухай хууль тогтоомж чигчид тухайн үед мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль оомжийн дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ**
**ХУРЛЫН ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

3 оны 5 дугаар ын 21-ний өдөр — Улаанбаатар хот

# ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь дайны байдал зарлах, цуцлах үндэслэл, улс ыг дайны байдалд шилжүүлэх үед авах үндсэн арга хэмжээ, түүнийг ижүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах үеийн төр, захиргаа, цэргийн далгын байгууллагуудын бүрэн эрх, байгууллага, аж ахуйн нэгж, ний хүлээх үүргийг тогтоож, дайны байдал зарласантай холбогдсон д харилцааг зохицуулахад оршино.

**дугаар зүйл. Дайны байдлын тухай хууль тогтоомж**

2.1. Дайны байдлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1], энэ ь, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас энэ.

---

дсэн хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дугээрт глэгдсэн.

2.2. Дайны байдал зарласнаас хойш энэ хуулийн заалт бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн тохиолдолд Дайны байдлын тухай хуулийн заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо**

"Дайны байдал" гэж Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл бий болох үед төрийн эрх барих дээд байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт тогтоох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн, цэргийн онцгой дэглэмийг хэлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Дайны байдал зарлах нөхцөл

**4 дүгээр зүйл. Дайны байдал зарлах нөхцөл**

4.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурдсан онцгой нөхцөл бий болсон үед дайны байдал зарлана:

4.1.1. улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон;

4.1.2. бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон.

**5 дугаар зүйл. Дайны байдал зарлах**

5.1. Дайны байдал зарлах тухай асуудлыг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл хэлэлцэж гаргасан шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, дайны байдал зарлах эсэхийг Монгол Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.2. Монгол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч дайны байдал зарлах тухай зарлиг гаргана. Улсын Их Хурал уг зарлигийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу хэлэлцэн 7 хоногийн дотор батлах, эсхүл хүчингүй болгоно.

5.3. Дайны байдал зарлах тухай Монгол Улсын хууль, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт дараах асуудлыг тусгана:

5.3.1. дайны байдал зарлах болсон онцгой нөхцөл байдал;

5.3.2. дайны байдлын зорилго;

5.3.3. дайны байдлын үед энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үндсэн арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэх хүрээ, заагийг бий болсон нөхцөлд нийцүүлэн тогтоох;

5.3.4. дайны байдал тогтоох нутаг дэвсгэрийн хил хязгаар;

5.3.5. хууль, зарлиг хүчин төгөлдөр болох хугацаа.

5.4. Дайны байдал зарласан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг дагаж мөрдөхөөс нь 6-аас илүүгүй цагийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

5.5. Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн

хиргааны төв байгууллага Монгол Улсад дайны байдал зарласан тухай ӀгдсэнҮндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, иплома харилцаатай улс орон, олон улсын бусад байгууллагад ндэгдэнэ.

**6 дугаар зүйл. Дайны байдлыг цуцлах**

6.1. Дайны байдал зарласан онцгой нөхцөл байдал бүрэн арилсан хай үндэсний аюулгүй байдлын хорооны саналыг үндэслэн Монгол лсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал дайны йдлыг цуцлах шийдвэр гаргана.

6.2. Дайны байдлыг цуцалсан тухай Улсын Их Хурал шийдвэр рамагц Монгол Улсын тайван цагийн бүх хууль тогтоомжийн үйлчлэл ргэж, дайны байдлын үеийн хууль тогтоомжийн актуудын үйлчлэл гсоно.

6.3. Дайны байдлыг цуцалсан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг н даруй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

6.4. Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн хиргааны төв байгууллага Монгол Улсад дайны байдал цуцалсан тухай лгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, пломат харилцаатай улс орон, олон улсын бусад байгууллагад дэгдэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Улс орныг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах, дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээ

**7 дугаар зүйл. Улс орныг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах үндсэн арга хэмжээ**

7.1. Тайван цагт дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.1.1. улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөг ловсруулах;

7.1.2. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагыг йны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд лжүүлэх бэлтгэлийг хангах;

7.1.3. зэвсэгт хүчний сургалт, бэлтгэл, цэргийн бүх шатны ирдлагын байгууллагуудын бэлэн байдлыг хангах;

7.1.4. улсын болон цэргийн дайчилгааны материаллаг нөөцийн ажээ, байршлыг тогтоож, түүнийг бүрдүүлэх, шинэчлэх, нөхөн сэлбэх;

7.1.5. улсын болон зэвсэгт хүчний хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллага, аж ахуйн нэгжийг дайны байдалд шилжүүлэх элтгэлийг хангах;

7.1.6. нутаг дэвсгэрийн хамгаалалт, цэргийн дэд бүтцийг өжүүлэх;

7.1.7. цэргийн бэлтгэл үүрэгтэнтэй дайчилгааны сургууль, ларалтыг хууль тогтоомжид заасны дагуу явуулах;

7.1.8. цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, тэдэнд эх орон хүмүүжил олгох, бие бялдар, оюуны өв тэгш хөгжлийг хангах тогтолцоо бүрдүүлэх.

7.2. Тайван цагт авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээг хууль тогтоомжоор тогтоож болно.

**8 дугаар зүйл. Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээ**

8.1. Дайны байдлын үед дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

8.1.1. улс орныг еренхий телевлегеений дагуу дайны байдал шилжүүлэх;

8.1.2. зэвсэгт хүчнийг бүх нийтийн буюу хэсэгчилсэн дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах;

8.1.3. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа шилжүүлэх;

8.1.4. дайны байдал тогтоосон нутаг дэвсгэрт дайны байдлын үеийн хууль тогтоомжийг мөрдүүлэх;

8.1.5. зэвсэгт хүчний хэвийн үйл ажиллагааг хангах, улс орон болон тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, хүн амын амьжиргааны зайлшгүй шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон тусгай дэглэм тогтоох;

8.1.6. өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, техник болон хүнс тэжээлийн нөөцийг нөхөх олговортойгоор дайчлах.

5.9. Уламжлалт технологи, шинжлэх ухаан, үйлдвэрийн нууцыг аалах, эрдэм шинжилгээний бүтээл, шинэ бүтээгдэхүүний загвар, аны тэмдэг, гарлын заалтыг эзэмших, ашиглах, арилжих онцгой йг патент, зохиогчийн эрхийн тухай болон бусад хууль тогтоомжоор аална.

## ЗУРГАА. Эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтныг дэмжих

6.1. Шинжлэх ухааны ач холбогдол, эдийн засгийн үр ашиг сайтай

бүтээл туурвих, дэвшилттэй технологи боловсруулах, түүнийг үйл
вэрлэлд түргэн хэрэглэхийг урамшуулсан тогтолцоо бүрдүүлнэ.

6.2. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлж байг
эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны цалин, урамшууллыг тэдн
мэдлэг, чадварын өсөлт, ажлын үр дүнг харгалзан нэмэгдүүлэх, нийгми
баталгааг сайжруулах арга хэмжээ авна.

6.3. Боловсрол, мэргэшлийн өндөр бэлтгэлтэй, чанар сайтай ол
шинжлэх ухаан, технологийн бүтээл туурвисан, тэдгээр нь үйлдвэрл
үйлчилгээнд амжилттай ашиглагдаж байгаа эрдэмтдийг насаараа э
чиглэлээр ажиллахыг дэмжин хэрэгжүүлнэ.

6.4. Үр бүтээлтэй ажиллаж байгаа эрдэм шинжилгээний ажилта
орон нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагаас урамш
олгох, бусад туслалцаа үзүүлэхийг бүх талаар дэмжинэ.

6.5. Захиалагч, ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага нь шинжг
ухаан, технологийн төслийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүл
ашигласнаас гарсан үр ашгийн тодорхой хувийг гүйцэтгэгчид урамш
болгон олгож байна.

## ДОЛОО. Шинжлэх ухаан, технологийн гадаад харилцааг хөгжүүлэх

7.1. Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг Засг
газраас гадаад орнуудтай байгуулсан олон улсын хамтын ажиллагаа
гэрээ, хэлэлцээрийн дагуу хөгжүүлж, энэхүү хамтын ажиллага
эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан, байгууллагууд ерөн оролц
бололцоог бүрдүүлнэ.

7.2.Нарийн мэргэжлийн хүн хүчний нөөцөө бэлтгэх, эрд
шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын сорилт, туршилтын баа
бэхжүүлэхэд олон улсын байгууллага, гадаад улсын зээл, тусламж
хөрөнгийн тодорхой хэсгийг зарцуулна.

7.3. Монголын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэм
Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагуудын
ажиллагаанд идэвхтэй оролцох, эдгээр байгууллагаас санхүү, техн
технологийн туслалцаа авч монголын шинжлэх ухаан, технолог
хөгжлийг дэмжих хамтарсан хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүл
олон улсын хэмжээнд эрдмийн солилцооны ажлыг бүх талаас дэмжинэ

7.4. Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгуулл
хоорондын шууд харилцааг өргөтгөх, энэ чиглэлээрхи санаачилга,
ажиллагааг бүх талаар дэмжинэ.

7.5. Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн байгууллага,
сургуулиуд, улсын номын сан, эрдэм шинжилгээний байгуулл
хоорондын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, энэхүү сүлж
дэлхийн шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, лавлагааны томоо
төвүүдтэй холбох талаар арга хэмжээ авна.

7.6. Шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжилтэй орнууд
шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлүүдээр нарийн мэргэжлийн эрд

өжилгээний ажилтан, судлаачдыг сургаж бэлтгэх, эрдэмтэд, эрдэм өжилгээний ажилтан, инженер, технологч нарыг урт, богино эцаагаар суралцуулах, ажиллуулах замаар мэргэжлийг нь шлүүлэн чадваржуулахад олон улсын байгууллага, гадаад улсын п, тусламжийн тодорхой хувийг ашиглах хэлбэрээр Монгол Улсын үны чадавхид хөрөнгө оруулна.

——oOo——

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

8 оны 5 дугаар ын 21-ний өдөр | Дугаар 57 | Улаанбаатар хот

**Засгийн газрын гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх үйн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний ий хуулийн 1 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны ийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, нууц санал алтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын даар Рэнчинсамбуугийн Одонбаатарыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 1998 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн ж мөрдөнө.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1 оны 5 дугаар ын 21-ний өдөр | Дугаар 58 | Улаанбаатар хот

**Ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх ийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэж, Засгийн газрын

гишүүнийг томилсонтой холбогдуулан Монгол Улсын Их Хура
ТОГТООХ нь:

1.Дамбийн Доржгиавыг Монгол Улсын Засгийн газрын гишү
Батлан хамгаалахын сайдын үүргэт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 1998 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс эх
дагаж мөрдөнө.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Дугаар 59 Улаанбаат хот

**Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дайны байдлын тухай хуулийг баталсантай холбогдуулан дара
арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ц.Элбэгдорј
даалгасугай:

1/ Засгийн газраас баталсан хүчин төгөлдөр мөрдөж бай
холбогдох тогтоол, шийдвэрийг 1998 онд багтаан Дайны байдлын ту
хууль тогтоомжтой нийцүүлэх;

2/ дайны байдлын үед үйлчилгээг зогсоох, хязгаарлах бо
тухайн үед мөрдөгдөх хууль, тогтоомжийн жагсаалт, төслийг 1999
багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/ энэ хуульд заасан дүрэм, журмыг 1999 оны I улиралд багт
гаргах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аюулгүй байд
гадаад бодлогын байнгын хороо /С.Зориг/-нд даалгасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

3 оны 5 дугаар
ын 28-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

**Санал хураах комисс байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:
Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох асуудлаар санал
аалтыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий комиссыг Улсын Их
лын гишүүн Батжаргалын Батбаяр, Э.Бат-Үүл, А.Болат,
энээ, Ү.Наранцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

3 оны 5 дугаар
ын 28-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

**Засгийн газрын гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн
дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай
ийн 1 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн
ийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, нууц санал хураалтын дүнг
глсэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:
.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэгээрлийн сайдаар
эдийн Сайханбилэгийг томилсугай.
.Энэ тогтоолыг 1998 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж
дөнө.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1998 оны 5 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 63 | Улаанбаат[...] хот

**Ажлаас чөлөөлөх тух[...]**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэ[...] 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дуг[...] зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэж, Засгийн газрын гишүүнийг томилсон[...] холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Чүлтэмийн Лхагважавыг Монгол Улсын Засгийн газрын гиш[...] Гэгээрлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 1998 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн да[...] мөрдөнө.

**ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1998 оны 5 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 64 | Улаанбаат[...] хот

**Нөхөн сонгууль зарлах ту[...]**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсг[...] 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 42 дугаар зүйлийн 1 хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 53 дугаар тойрог дахь нө[...] сонгуулийн санал хураалтыг 1998 оны 7 дугаар сарын 5-ны ө[...] явуулахаар тогтоосугай.

2.Энэ тогтоолыг 1998 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн да[...] мөрдөнө.

**ДАРГА** **Р. ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 5 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

**Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн ахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн нгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 53 дугаар тойрогт явуулах ;өн сонгуульд улсын төвлөрсөн төсвөөс зарцуулах зардлын хэмжээг 04.300 төгрөг байхаар тогтоосугай.

2.Нөхөн сонгуульд зарцуулах зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолыг 1998 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж здөнө.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 5 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

**Р. Шибаг "Алтан гадас" одонгоо нэхэн шагнах тухай**

Монгол Улсын түүх, соёлын талаар олон бүтээл туурвиж, япон ард түмэнд сурталчлан таниулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Япон Улсын иргэн нэрт түүхч, зохиолч агсан Шиба Рёотароо- "Алтан гадас" одонгоор нэхэн шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 5 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

**В. М. Солнцевийг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, ОХУ-ын шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, монгол судлал, хэл шинжлэлийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн захирал, Олон улсын Монгол судлалын холбооны дэд ерөнхийлөгч Вадим Михайлович Солнцевийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

8 оны 5 дугаар
ын 5-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

**В. С. Хохловыг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, ОХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад иддаа, банк санхүүгийн салбар дахь харилцаанг өргөтгөн күүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Москва дахь йн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны Ерөнхий зоны дарга Виталий Сергеевич Хохловыг "Найрамдал" медалиар насугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

оны 5 дугаар
ын 5-ны өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

**Жон Боклерийг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монголын хүүхэд багачуудын төлөө олон төсөл хэрэгжүүлж, ий нийгмийн байдлыг сайжруулах, сургуулийн өмнөх боловсрол шүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Английн шийг ивээх сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын лбөрийн зохицуулагч Жон Боклерийг "Найрамдал" медалиар насугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 5 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

**Кристин Мусисийг "Найрамд[al] медалиар шагнах тухай**

Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн эхний шат зорилтуудыг төв, орон нутагт хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмр нь үнэлж Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын зөв мэргэжилтэн, НҮБ-ын сайн дурын ажилтан, Уганда Улсын ир Кристин Мусисийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 5 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

**Пол Окюстыг "Найрамдал" медал шагнах тухай**

Монгол Улсын төр, засгийн байгууллагын чадавхийг дээшлүүл төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт шинэчлэл гүнзгийрүүлэх, үндэсний боловсон хүчнийг сургахад оруулсан х нэмрийг нь үнэлж НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ахлах зөвлөх П Окюстыг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНД**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
# ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 3 оны 5 дугаар<br>ын 21-ний өдөр | Дугаар 53 | Улаанбаатар<br>хот |

ОХУ-ын зарим иргэдийг шагнах тухай

Монгол Улсад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж гаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн дор дурдсан хүмүүсийг алиар шагнасугай.

**"Найрамдал"** медалиар:

| | |
|---|---|
| 1. Владимир Ильич Дмитриев | - ОХУ-ын Эрхүү хотын Улсын их сургуулийн орлогч захирал |
| 2. Васса Михайловна Манжеева | - Эрхүү хотын Төмөр замын тээврийн инженерийн дээд сургуулийн гадаад хэлний тэнхмийн багш |

**Хөдөлмөрийн** хүндэт **медалиар:**

| | |
|---|---|
| Галина Иннокентьевна Гунгуова | - Эрхүү хотын Улсын их сургуулийн орос хэлний тэнхмийн эрхлэгч |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 5 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

**Г. Т. Пличукийг "Найрамд[ал]" медалиар шагнах тухай**

Монгол Улсад олон барилга байгууламжийг барьж ашиглал[тад] оруулах, монгол иргэдийг ажлын байраар хангахад оруулж бай[гаа] хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар дахь ОХУ-ын "Зарубежстр[ой]" компанийн ерөнхий инженер Григорий Тихонович Пличук[ийг] "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 68 | Улаанбаатар хот

**Д. Б. Улымжиевийг "Алтан гад[ас]" одонгоор шагнах тухай**

Монгол Улс, ОХУ-ын шинжлэх ухааны байгууллагын хамт[ын] ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, манай улсад мэргэжил[тэй] боловсон хүчин, эрдэмтэд бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Их сургуули[йн] захирлын зөвлөх Даши Батуевич Улымжиевийг "Алтан гад[ас]" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНД[И]**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

оны 6 дугаар
і 2-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

**Ү.Цэдэнбалд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай**

деө аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, цсан аж ахуйн нэгжийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг нүүлж, хөдөөгийн хөдөлмөрчдөд үр өгөөжтэй үйлчлэн зуучилж, й эрэлт хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь : Ховд аймгийн Манхан сумын "Манай зам" ХХК-ийн захирал нгийн Цэдэнбалд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол эсүгэй.

**ОНГОЛ УЛСЫН**
**ӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

оны 6 дугаар
2-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

**Ч. Оросоод Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

үүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, й мэс заслын дэвшилтэт шинэ аргуудыг эмчилгээнд үлэн хөдөөгийн хүн амд эмнэлгийн нарийн мэргэжлийн ж үзүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дорнод йн Нийгмийн эрүүл мэндийн төвийн нүдний тасгийн эрхлэгч, ч Чимидийн Орсоод Монгол Улсын хүний гавьяат эмч цол сүгэй.

**ОНГОЛ УЛСЫН**
**ӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 6 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 71 | Улаанбаата хот

Б. Дамдиндоржид Монгол Ул
хүний гавьяат эмч цол хүртэ
тухай

Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээл
ажиллаж төрөх эмэгтэйчүүдийн эмчилгээний дэвшилтэт аргуу
нэвтрүүлж, эх нялхсын эндэгдэл, төрөлт жирэмслэлтийн хүндрэл
бууруулан, тэдний эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа э
нэмрийг нь үнэлж Хөвсгөл аймгийн Нийгмийн эрүүл мэнд
төвийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч Базарын Дамдиндор
Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** Н. БАГАБАН

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1998 оны 6 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 72 | Улаанба хот

Ж. Гантөмөрт Монгол Ул
гавьяат жүжигчин цол хүр
тухай

Дэлхийн сонгодог болон үндэсний олон дуурийн гол дүрү
мэргэжлийн өндөр ур чадвар гарган амжилттай тоглон үзэгч о
талархал хүлээж дуурийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа э
нэмрийг нь үнэлж Сонгодог урлагийн академик театрын гоц
дуучин Жанчивын Гантөмөрт Монгол Улсын гавьяат жүжигчин
хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** Н. БАГАБАНД

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

8 оны 6 дугаар ын 2-ны өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

**Л. Баттуулд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж олон ан бүжгийг мэргэжлийн өндөр ур чадвар гарган гоцлон бүжиглэж, эиг дэглэх, бүжгийн жүжгийн гол дүр бүтээх, бүжгийн урлагийг жүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Үндэсний дуу, гийн "Жамуха" чуулгын гоцлол бүжигчин Ламжавын Баттуулд нгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

8 оны 6 дугаар ын 2-ны өдөр | Дугаар 74 | Улаанбаатар хот

**А. Доржсүрэнд Монгол Улсын спортын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай**

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, нтэй тамирчин олноор нь бэлтгэж, дасгалжуулсан баг тамирчид лсын аварга шалгаруулах тэмцээнээс 200 гаруй алт, мөнгө, хүрэл аль авч, хөдөө орон нутагт гар бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд лж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь аймгийн Мандалговь ын 10 жилийн I дунд сургуулийн биеийн тамирын багш Анжийн жсүрэнд Монгол Улсын спортын гавьяат дасгалжуулагч цол рээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 6 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 75 | Улаанбаатар хот |

**Л. Гантөмөрт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх туха**

Ерөнхий боловсролын сургуульд бага ангийн багш, эрхлэгчээ 30 гаруй жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж, заах аргы хэд хэдэн ном, гарын авлага бичиж, шавь нартаа суурь мэдлэгий даацтай олгож, олон залуу багш нарыг ажилд нь дадлагажуулан өсвө үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг и үнэлж Нийслэлийн 10 жилийн 6 дугаар сургуулийн бага ангий багш, хичээлийн эрхлэгч Лхамын Гантөмөрт Монгол Улсын гавьяа багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 6 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 76 | Улаанбаатар хот |

**Зарим ахмад дайчныг одонгоо шагнах тухай**

Эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үй хэрэгт оруулсан гавьяаг нь үнэлж дор дурдсан ахмад дайчды одонгоор шагнасугай.

### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

| | |
|---|---|
| Гэндэнгийн Дамдин | - Нийслэлийн Сүхбаатар дүүр гийн 4 дүгээр хорооны иргэ ахмад дайчин |

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

| | |
|---|---|
| Заяжихын Даш | - Увс аймгийн Өндөрхангай сумын иргэн, ахмад дайчин |
| Очирын Түмэн-Өлзий | - Ховд аймгийн Мөст сумын иргэн, ахмад дайчин |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1 оны 6 дугаар<br>ын 2-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар<br>хот |

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, отын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

| | |
|---|---|
| . Янжингийн Баатар | -Биеийн тамир, спортын "Алдар" нийгэмлэгийн "Мөнгөн хигээс" клубийн захирал |
| 2. Балжиннямын Доржсүрэн | -Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн ундраа" цогцолбор сургуулийн физикийн багш |
| 3. Чойнжуурын Нүүнээ | -Увс аймгийн "Бэлбулаг" хоршооны инженер |
| . Жавын Пүрэв | -"АПУ" ХК-ийн худалдаа үйлчилгээний төвийн захирал |
| . Ёндонгийн Сүхээ | -Бор-Өндөрийн уулын баяжуулах комбинатын цехийн дарга |

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

| | |
|---|---|
| 1. Төмөр-Очирын Баламсэд | - Хэвлэлийн "Шувуун саар УҮГ-ын захирал |
| 2. Болдын Батнасан | -Сүхбаатар аймгийн Баруун-сумын 8 жилийн дунд сурі лийн захирал |
| 3. Цэндийн Баттөмөр | -Төв Азийн "Уран" ХХК-і Чойбалсан хотод суугаа төл лөгч |
| 4. Буяндэлгэрийн Борхондой | - "Өнгөт хэвлэл" ХК-ийн зөвл |
| 5. Дамдилын Бямбаа | -Өмнөговь аймгийн Гурван сумын "Соёл" ХК-ийн захирал |
| 6. Дорлигийн Дамдин | -Монголын хүнсчдийн холбоо нарийн бичгийн дарга |
| 7. Жамбалдоржийн Дашдорж | -"Монголросцветмет" нэгдлі эдийн засгийн хэлтсийн дарга |
| 8. Пүрэвдоржийн Дорж | - Нийслэлийн Боловсролын і рын дарга |
| 9. Сэрээтэрийн Доржзэрэм | - Дархан-Уул аймаг дахь "Монгол алт" ХК-ийн ал уурхайн дарга |
| 10. Шадавын Жавзан | - "АПУ" ХК-ийн ахлах эді засагч |
| 11. Цэвэгсүрэнгийн Жанлав | -Дорнод аймгийн мах үйлдвэр лийн "Дорнод" ХК-ийн ерөн захирал |
| 12. Навааны Лувсанжамбаа | -Хэнтий аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн их эмч |
| 13. Оросоогийн Люваанжав | -Нийслэлийн 95 дугаар сурі лийн бага ангийн багш |
| 14. Бадарчийн Отгонбаяр | -Монголын дүлий иргэдийн ейн тамир, спортын холбоо ерөнхийлөгч |
| 15. Шатарын Тогоо | -Өвөрхангай аймгийн С сумын "Сантмандал" ХК-і захирал |
| 16. Төмөр-Очирын Түдэвринчин | -Өвөрхангай аймгийн түүхий эд бэлтгэлийн газ дарга |
| 17. Хишигийн Цэцэн | -Хөнгөн үйлдвэрийн салб мэргэжилтнээр ажиллаж байса |

| | |
|---|---|
| 18. Шагдарсүрэнгийн Эрдэнэбилэг | -УБХТН-ийн автомото спортын төв клубын ахлах багш |

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

| | |
|---|---|
| 1. Цэрэндүгийн Болдбаатар | -Хэнтий аймаг дахь Бэрхийн уулын үйлдвэрийн нэвтрэгч |
| 2. Осорын Долгоржав | -Нийслэлийн 34 дүгээр дунд сургуулийн багш |
| 3. Равагийн Дулмаа | -Нийслэлийн 72 дугаар цэцэрлэгийн эрхлэгч |
| 4. Бадамын Төмөрбаатар | -Барилгын цахилгаан, сантехникийн угсралтын "Хүрд" ХК-ийн цахилгаанчин |
| 5. Сүхийн Цангиа | -Дундговь аймгийн Сайнцаган сумын 8 жилийн сургуулийн бага ангийн багш |
| 6. Бямбын Чулуун | -Баянхонгор аймгийн "Мөнгөн үсэг" компанийн хэвлэгч, үсэг өрөгч |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н. БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998 оны 5 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаата хот

**Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улс Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогто Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай**

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 1998 оны 5 дуга сарын 6-ны өдөр Төрийн ордны 480 тоот өрөөнд үйлдэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэци гишүүн Ж. Бямбажав даргалж, гишүүдэд Л. Баасан /илтгэг Ж. Бямбаа, С. Жанцан, Ч. Энхбаатар нарыг, нарийн бичгийн да гаар Б. Цэндээхүүг тус тус оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанд гомдол гаргагч иргэн Л. Ганб Б. Дондогмаа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлө Д. Лүндээжанцан, Р. Бадамдамдин, М. Зэнээ нар оролцов.

Нэг. Төв аймгийн Архуст сумын Засаг дарга, мөн сум иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга ажилтай Гунгаадаши Шагшаа, Дугарсүрэнгийн Шарав нараас Үндсэн хуулийн Цэц хандаж гаргасан өргөдөлдөө: "Манай сум 1955 онд Архуста сангийн аж ахуй нэрээр анх байгуулагдаж, 1969 онд Архуста тэжээлийн аж ахуй, 1976 онд хороо, 1981 оноос Төв аймгийн Арх сум гэх мэтээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэ болон үүсч хөгжиж ирсэн бөгөөд сумын нутаг дэвсгэрийн хили цэсийг БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн /тэр үеи нэрээр/ 1982 оны 131 дүгээр зарлигаар тогтоосон юм. Тус с 547 өрх, 2047 хүн, 49080 толгой малтай газар тариалан эрх 2 компанитай, өндөр хүчдэлд холбогдсон төмөр замын сүлжээт дэд бүтэц харьцангуй хөгжсөн сум болно.

Гэтэл Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолоор нийсл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчл тогтоохдоо тус сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоос Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлиги хүчингүй болгожээ.

Ингэснээр Архуст сум нутаг дэвсгэргүй болж, манай зэргэлд Эрдэнэ, Баяндэлгэр, Баянжаргалан сумд урьд өмнө нь манай сумз шилжүүлсэн нутгаа буцааж авна гэсэн хандлага үүсгэж, малч иргэд хооронд хэрүүл маргаан үүсч ноцтой байдал бий болоод байн

лсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 3 дугаар заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т заасан г захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн йн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, ийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ" гэсэн ыг; мөн хуулийн 58 дугаар зүйлийн 1,2-т заасан "Аймаг, сум, г бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага й засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засгийн цогцолбор , "Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн ын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална" гэсэн уудыг; мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн , түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2,4 дүгээр йн 1,3 дахь заалтуудыг тус тус зөрчиж, тус сумыг үндсэнд нь дэвсгэргүй болгосон буруу шийдвэр гэж үзэж байна. Иймд н Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолыг хянан үзэж, уг олын 3 дугаар заалтыг хүчингүй болгож, манай сумын нутаг эрийг 1982 онд тогтоосон хуучин байдлаар нь үлдээж өгөхийг " гэжээ.

эр. Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга ажилтай, иргэн Ганбат, мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үлэгчдийн дарга ажилтай, иргэн Б. Дондогмаа нараас Үндсэн йн Цэцэд хандаж ирүүлсэн өргөлдөө: "Монгол Улсын Их ын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор элийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоохдоо нэ сумын 1,2 дугаар багийн нутаг Туул, Тэрэлжийн гол, Элстэй, ины амны сав газрын 49.5 мянган га газрыг шилжүүлж, уг вэрийг хэрэгжүүлж байгаа юм. Улсын Их Хурлын дээрх вэр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын йн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулахтай холбогдсон Монгол н Газрын тухай хуулийн 21, 25 дугаар зүйл, Монгол Улсын йн газрын 1995 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Газар эн байгуулалтын журмын 9, 20, 21 дүгээр зүйлүүдийн заалтуудыг ус зөрчсөн байна.

сгийн газар дээрх шийдвэрийг гаргуулахдаа зохих мэргэжлийн уллагын санал болон тогтоолынхоо дагуу ажлын хэсэг гарган материал бүрдүүлэхгүйгээр дангаараа санал боловсруулан лыг шийдвэрлүүлсэн. Энэхүү шийдвэр нь:

Тус сумын 2 багийн 74 өрхийн 225 иргэн, 85 өвөлжөө, жаа болон суурин хашаа, байшин 6000 гаруй мал хохирч буй ... нийслэлд шилжүүлснээрээ нутгийн иргэдийг олон зуун йн турш амьдарч ирсэн нутгаас нь салгаж, ахуй амьдралд нь ар нөлөөлж байна.

4

2. Сумын төсвийн орлогын 70 хувийг оруулах үйлдвэр үйлчилгээ, амралт, аялал жуулчлалын 10 гаруй аж ахуйн цаашид бие даан ажиллах боломжгүй болох ба ингэснээр тус эдийн засгийн хувьд биеэ даан оршин тогтнох боломжоо а Монгол Улсын Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дүгээрт з "Сум . . . бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удир бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийг цогцолбор мөн" гэсэн заалт зөрчигдөж байна.

3. Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дугаар зүйлд буй " захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн зас бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Х иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ" заалтыг зөрчиж манай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Х нутгийн иргэдийн саналыг авахгүйгээр асуудлыг шийдвэрлэсэн х

Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолын 1 дэх заалт нь тус с хоёр багийн иргэдийг нутаггүй болгож, Улаанбаатар хотын и нутгийн уугуул иргэдийн хооронд нутгийн маргаан үүсгэж, у иргэдийн санаа сэтгэлийг алдагдуулж байгааг харгалзан Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийг зөрчсөн үзэж байгаа тул шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

**Гурав.** 1. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлө Д. Лүндээжанцан, Р. Баламдамлин нараас иргэн Д. Ш Г. Шагдаа нарын өргөдөлтэй холбогдуулан бичгээр ирү тайлбартаа: "Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэ тогтоох тухай тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн санаачилан Улсын Их Хуралд оруулсан. . . . Нийслэлд хэт төв бий болж, нутаг дэвсгэрийн хүрэлцээ муудсанаас хотод о суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил улам бэрхшээ болсон, Төв аймгийн нутагт нийслэлийн харьяалалд б захиргааны нэгжүүд бий болж, Үндсэн хууль зөрчигдөж б болон бусад шаардлагын дагуу дээрх тогтоолын төсөл боловсро ба Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны хуралда хэлэлцэгдэж, 79.6 хувийн саналаар батлагдсан. Уг тогтоол нь Мо Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Тогтоолоор газар нутгийн хилийн цэсийг тогтоосон болохоос нэгэнт тогтсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өө асуудлыг хөндөөгүй байна. Улсын Их Хурал нь нийслэл, тү дүүргүүдийн хилийн цэсийг батлахдаа Монгол Улсын Үн хуулийн 58 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэсэн гэж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах холбогдуулан Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэрг Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэ

эвсрүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт ггасан. Харин Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны дүгээр зарлигийг хүчингүй болгосон нь нийслэлийн хилийн цэс хлөгдсөнтэй холбоотой. Архуст, Баянжаргалангийн хилийн цэст өрчлөлт оруулаагүй. Үүнийг Засгийн газраас дээрхи сумдын хилийн цэсийг оруулж ирэхдээ хамтад нь оруулж ирэх боломжтой байна" ээ.

2. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д. Лундээжанцан, Бадамдаамдин нараас Төв аймгийн Эрдэнэ сумын иргэн Дондогмаа, Л. Ганбат нарын гомдолтой холбогдуулж бичгээр ирүүлсэн тайлбартаа: "Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоол нь Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй гэж үзэн дараахь зүйл барыг гаргаж байна. Үүнд:

/ Улсын Их Хурлын энэхүү тогтоол нь газар нутгийн хилийн цэсийг тогтоосон болохоос биш нэгэнт тогтсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг хөндөөгүй байна. Төв аймгийн Эрдэнэ сумм, нийслэлийн Налайх дүүрэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд өөрчлөлт ороогүй.

Улсын ИИх Хурал нийслэл түүний дүүргүүдийн хилийн цэсийн зааг хилийг баталхдаа Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийг үндэслэсэн гэж үзэж байна.

/ Улсын Их Хурлын энэ тогтоол нь Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дүгээр заалтанд буй "Аймаг, нийслэл, сум, дүүрэг болон тэдгээр тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн" гэсэн хэм хэмжээг зөрчөөгүй. Эрдэнэ сум нь 1996 онд энэ тогтоол гарахын дараа 3.5 мянган хүн амтай, 57.0 мянган толгой малтай, ) мянган га газар нутагтай, үүнээс 433.0 мянган га нь ХАА-н эргэлтийн газартай байв. Эрдэнэ сумаас нийслэлд 48.9 мянган га ) шилжүүлсний 30.8 мянган га нь бэлчээрийн эдэлбэр, мянган га нь тариалангийн эдэлбэр газар бөгөөд Улсын Их Хурлын баталсан дээрх нутагт одоо Налайх дүүргийн 22.0 мянган 54.0 мянган мал, нийслэлийн 49 албан байгууллага, аж ахуйн нэгжийн 20.1.0 гаруй толгой мал, Тэрэлж амралт, Жуулчдыг үйлчлэх ), Болорр зуслан, Чингисийн өртөө, Нарлаг, Жавхлант зэрэг аж н нэгж, байгууллагууд байдаг юм. Энэ нутагт 1996 оны байдлаар гаруй өрх хаваржиж байсан бөгөөд үүнээс 270 гаруй нь Налайх гийн, 300 гаруй нь Эрдэнэ сумын харьяат айл байна. Мөн энэ г дэвсгэрт 106 өвөлжөө, хаваржаа байгаагаас 20 гаруй нь Эрдэнэ их, бусад нь Налайх дүүрэг Улаанбаатар хотын иргэдийнх юм.

Шилжүүлэхээр шийдвэрлэсэн нутгийн хилийн цэсийн гадна талд нэ сумын нутагт Налайх дүүргийн Шохойн хоёр уурхай, Ар чивлан болон тэр орчмын 226 өрхийн 724 хүн, 59 өвөлжөө,

хаваржаа, 11.2 мянган толгой мал үлджээ" гэжээ.

**Дөрөв.** Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч М. Зэнээгэ бичгээр ирүүлсэн тайлбартаа: "1. Нийслэлийн нутаг дэвсгэрий хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1996 он 24 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь заалт мөн хуулийн 58 дугаар зүйлийн 2 дахь заалт, Монгол Улсын Заса захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулий 3 дугаар зүйлийн 2, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтууды тус тус зөрчсөн;

2. Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 3 дугаа заалтад БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 он 6 дугаар сарын 1-ний 131 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон н нэгэ "зарлигийг" гэснийг тогтоол гэж алдсан; хоёрт бүхэл бүтэ Архуст сумыг хууль бусаар татан буулгасан буруу шийдвэр болсон;

3. Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол нь Үндсэ хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь заалт болох сумын иргэдий Төлөөлөгчдийн Хурал болон ард олноос ямар ч санал аваагүй ган тал болох нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр Засгий газар Улсын Их Хуралд оруулж, түйлшруулан шийдсэн буруу тогто болсон;

4. Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол нь газа зохион байгуулалтын журам зөрчиж хилийн цэс тогтоох комис Засгийн газраас томилж ажиллуулаагүй, газар зохион байгуулалты асуудлыг Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас эр олгосон байгууллагаар дамжуулан хэрэгжүүлээгүй зэргээр Монго Улсын Газрын тухай хууль, Засгийн газраас баталсан газар, зохио байгуулалтын журмыг зөрчсөн. Иймд Улсын Их Хурлын 1996 он 24 дүгээр тогтоолыг хүчингүй болгож өгнө гэдэгт гүнээ итгэж Үндсэн хуулийн Цэцэд хандаж байгааг анхааралдаа авах болов уу гэжээ.

**Тав.** Гомдол гаргагч иргэн Д. Шарав, Г. Шагшаа нараас 1998 он 4 дүгээр сарын 23-ны өдөр бичгээр ирүүлсэн тодорхойлолтондо "Сумынхаа нутаг дэвсгэрийн тухай такайд хандаж гаргасан өргөдөл дурьдсан асуудлыг Улсын Их Хурлын энэ өдрийн хуралдаанаа хэлэлцэж, Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолын 3 дугаар заалты өөрчлөн найруулж, манай сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсий өмнө байсан хэвээр нь байлгахаар /Ардын Их Хуралы Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийн холбогдох заалты сэргээн/ тогтоол гаргаж байгаа учир бид гаргасан өргөдлө шийдвэрлэгдлээ гэж үзэж байна гэжээ.

**Зургаа.** Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрий 42 дугаар тогтоолд "Нийслэлийн хилийн цэсийг шинэчлэн тогто тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны

ийн 24 дүгээр тогтоолын 3 дахь заалтын "131 дүгээр зарлигийг" ийг "1131 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралтыг" гэж өөрчилсүгэй" юэ.

**Цолоо.** Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож иргэн Ганбат тайлбарлахдаа: "1. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн өлөгч Д. Лүндээжанцангийн бичгээр гаргасан тайлбарт тоо имтыг буруу дурьдсаныг Үндсэн хуулийн Цэц анхаарах байхаа гт итгэнэ.

. Нийслэлд манай сумын орлогын эх үүсвэр болох газар нутгийг жүүлснээс тус сум төсвийн орлогын 70 хувиа алдаж, оршин нох нөхцөлөө алдаад байна. Ингэснээр хууль зөрчигдөхөд хүрээд ча.

. Бид нийслэлд газар өгөхгүй гэж үзээгүй. 16.0 мянган га газар өөр зөвшөөрсөн. Гэтэл Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолоор лэлд Төв аймгаас өгөх нутгийг нэмэгдүүлсэн. Бид гомдлын эдлагаа дэмжинэ" гэв.

**Пайм.** Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож иргэн Донлогмаа тайлбарлахдаа: "1. Нийслэлд 48.9 мянган га газар жсэн биш 61.6 мянган га газар өгчээ. Үүнийг бид эрх бүхий уулллагуудаар тодорхойлуулсан.

. Налайх, Төв аймгийн Эрдэнэ сумын хооронд нутгийн маргаан гүй, хоорондоо эв найртай аж төрж ирсэн болно.

Налайх, Эрдэнэ сумын хооронд нутгийн хилийн цэсийг рхой болгохдоо нийслэлийн болон Төв аймгийн нутаг эрийн хилийн цэсийг давхцуулсан. Үүнийг Улсын Их Хурлын оны 4 дүгээр сарын 23"-ны өдрийн 42 дугаар тогтоолоор улам гаажуулжээ.

нд Цэцэд гаргасан өөрсдийн өргөдлийн шаардлагаа дэмжих о" гэв.

**с.** Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д. Лүндээжанцан ийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: "1. Улсын Их Хурлын жлэгдсэн төлөөлөгчийн хувьд Улсын Их Хурлын шийдвэрээ алах үүрэгтэй гэдгээр асуудалд хандана. Миний тайлбарт байгаа м нэгэн тоо бол 1996 оных. Иймд одоогийнхтой зөрж болно.

Эрдэнэ сумыг Үндсэн хуульд заасан цогцолбор байх нөхцөлөө з гэж үзэх боломжгүй. Эднийд эдийн засаг, газар нутгийн бусад лцоо бий. Чухамдаа сумын орлогын эх үүсвэр үгүй болсон гэх слэлгүй байна.

Улсын Их Хурал нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг цгүй хэрэглээг харгалзан шийдвэрлэжээ. Энэ үед Засгийн ын ажилтан Банзрагч тэргүүтэй комисс ажилласан ба энэ сст Төв аймгийн зохих сумдын Засаг дарга нар оролцсон. исс хээрийн ажлын тайлан бичсэн. Энэ тайланд нутаг

дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх саналуудыг тусгасан, бас газр
зураг гаргасан. Энэхүү зургийг 4 удаа гаргасан. Улсын Их Хурал
олон зургийн дотроос дундаж хувилбарыг баримталсан. Үүг
Эрдэнэ сумаас 48.9 мянган га газрыг нийслэлд шилжүүлэх боло
Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогт
тухай асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хур
шийдвэрлэсэн.

Эдгээр байдлуудаас үндэслэн Улсын Их Хурлын 1996 о
24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэлгүй бай
Үндсэн хуулийн Цэц хуулийн хүрээнд ажиллана гэдэгт итгэж бай
гэв.

**Арав.** Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч М. Зэ
Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: "
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд Улсын
Хурлынхаа шийдвэрийг хамгаалах ёстой боловч уг шийдвэр Мон
Улсын Үндсэн хуулийг зөрчсөн учир сөрөг саналтай байна.
талаар бичгээр санал өгсөн. Улсын Их Хурал тогтоол гаргах
нийслэлийн нутгаа тэлж өргөтгөх хандлагаар хандаж туйлшир
үүнд Эрдэнэ сум 16.0 мянган га газар өгнө гэж зөвшөөрсөн бай
одоо 61.6 мянган га болоод байна. Ерөнхийлөгч П. Очирбат
асуудлаар Засгийн газар, Улсын Их Хуралд олон удаа хандаж байс
Ер нь газар бол аль нэг газар, байгууллагын эрх ашгийн үүдн
хандаж болохгүй эмзэг асуудал болно. Иймд Үндсэн хуулийн Ц
асуудалд бодитой хандаасай гэж хүснэ" гэв.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Р. Бадамлам
"Улсын Их Хурал нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэс
тогтоохдоо анх санаачлан оруулсан саналыг багасгаж шийдвэрлэ
юм шүү дээ. Үүнийг тэр үед ажлын хэсэгт ажиллаж бай
нийслэлийн Засаг дарга Наранцацралтаар яриулмаар байна".
гэрээр газрын зураг дээр тайлбарлав.

ХЯНАВАЛ:

1. Улсын Их Хурал нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэс
шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Үнд
хуулийн 58 дугаар зүйлийн 2-т буй "Аймаг, нийслэл, сум, дүүрг
хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Ху
батална" гэсэн заалтыг баримталсан тул Төв аймгийн Эрдэнэ сум
иргэн Л. Ганбат, Б. Дондогмаа нарын гомдлыг хангах үндэслэл
байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэх асууд
боловсруулахдаа Монгол Улсын Газрын хууль, Монгол Ул
Засгийн газраас тогтоосон газар зохион байгуулалтын журам зөрч

1 гомдол нь Үндсэн хуулийн Цэцийн харьяаллын асуудал биш
к нь тогтоогдов.

Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн
угаар тогтоолоор Төв аймгийн Архуст сумын нутаг дэвсгэрийн
йн цэсийг хуучин байдлаар нь /БНМАУ-ын Ардын Их Хурлын
үлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигаар/ тогтоосон учир
н Д. Шарав, Г. Шагшаа нар Үндсэн хуулийн Цэцэд гаргасан
лоосоо татгалзсан тул энэ талаар Үндсэн хуулийн Цэцээс
лт гаргах хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдов.

Іонгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн
д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын
ийн 31, 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ
АХ нь:

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн
ох тухай Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны
йн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 57
р зүйлийн 3 дахь хэсгийн "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн
ийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг
лзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын
Хурал шийдвэрлэнэ", мөн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх
йн "Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон
үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр,
н засаг, нийгмийн цогцолбор мөн", мөн зүйлийн 2 дахь хэсгийн
аг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын
н мэдүүлснээр Улсын Их Хурал батална" гэсэн заалтуудыг тус
эрчөөгүй байна.

Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор
н хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

АРГА
ИШҮҮД

Ж. БЯМБАЖАВ
Л. БААСАН
Ж. БЯМБАА
С. ЖАНЦАН
Ч. ЭНХБААТАР

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998 оны 6 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 06

Улаанба хо

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурл сонгуулийн тухай хуулийн зарим з Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн дугаар зүйлийн 9, 14 дүгээр зүйлв 1-ийг зөрчсөн эсэх тухай**

Үндсэн хуулийн Цэцийн энэ дүгнэлтийг 1998 оны 6 дугаар с 3-ны өдөр Төрийн ордны 251 тоот өрөөнд үйлдэв.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Л. Б даргалж, гишүүн Н. Жанцан, Ж. Бямбаа, Д. Чилхл Ж. Бямбажав /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, Цэцийн на бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Т. Ядамсүрэн, Улсын Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Баярцогт, Т. Эрдэнэбилэг оролцов.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 3 дугаар багт оршин иргэн Т. Ядамсүрэн Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд ха гаргасан өргөдөлдөө: "Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-д "за эрх ард түмний мэдэлд байна. ... ард түмэн төрийн үйл хэрэгт оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгч байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", мөн хуу 16 дугаар зүйлийн 9-д "шууд буюу төлөөлөгчдийн байгууллаг уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй", мөн хуу 14 дүгээр зүйлийн 1-д "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх байна" хэмээн монголын иргэд тэгш эрх эдэлж төрийн хэ төрийг удирдахад оролцох эрх, эрх чөлөөг тов тодорхой заасан би

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Ху сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1-д " төлөөлөгчдийн тоо нь гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд п сонгууль явуулна" гэсэн заалт нь Үндсэн хуулиар олгосон ирг эрхийг /дээр дурьдсан/ хааж байна" гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд хандан и Т. Ядамсүрэн бичгээр гаргасан тайлбартаа: "Монгол Улсын Үн хуулийн 3 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 16 дугаар зүйлийн заасан эрх дараах байдлаар хэрэгждэг гэж би ойлгодог. Үүнд:

... өөрийн итгэж, найдвар хүлээлгэж чадах хүнээ өөрөө мэдэж, гэй, шууд сонгох, эгүүлэн татах явдал мөн.

Төр, засгийн болон орон нутгийн удирдлагад сонгосон ын төлөөлөгчтэй байж, тэдэнд санал бодлоо илэрхийлэх замаар н хэрэгт оролцох ёстой.

УИХ-ын гишүүн, Ерөнхийлөгч болон орон нутгийн Хурал, лагаа шууд сонгох;

. . . төлөөллийн тоог тодорхой хэмжээгээр хуульчлан тогтоож ь нь иргэний эрх, хуулийн өмнө тэгш байх зарчмыг аажуулсан хэм хэмжээ мөн.

маг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын лийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн д заасан нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн байна.

хангай аймгийн Батцэнгэл сумын 262 иргэн нөхөн сонгууль к өгөөч гэсэн хүсэлтийг удаа дараа гаргасан боловч тэдний йиг хуулийн дээрхи заалт хааж байна" гэжээ.

ын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Баярцогт, эзэнбилэг нар бичгээр гаргасан тайлбартаа: "Тус хуулийн үзэл тлал нь сонгууль явуулахдаа пропорциональ зарчмыг илүү эсэн тул сонгуулийн үед намын жагсаалтанд багтаж байсан эшигчдийг автоматаар нөхөн сонгох онцлогтой гэдгийг лан анхаарах нь зүйтэй бөгөөд сум бүрээс заавал тогтмол нолтэй байна гэсэн хатуу зарчмыг аль ч хуулинд мөрдөг к баримталдаггүй болохыг анхааран үзэхийг хүсье" гэжээ.

гэн Т. Ядамсүрэн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан ртаа: "Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол ч хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг, төрөөс баталсан р сонгогдож байгуулагддаг нийм л байгууллага. Төрийн дээд бусад байгууллагатай иргэдийг холбож байдаг ганц байгууллага үү. Хэрэв төрийн биш байгууллага юм бол бүх ажиллагааг нь лалгүй биднэд эрхийг нь өгөхгүй явсан юм бэ? Тоог нь р тогтоосон атлаа хасагдахаар нь нөхөж болдоггүйн учир юу жээ.

нгол Улсын Их Хурлын итгэмлэгдсэн төлөөлөгч С. Баярцогт, эзэнбилэг нар Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож рлахдаа: "Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь өөрөө х ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчимд тулгуурлаж, чийн идэвхтэй, идэвхгүй эрхийг хэрэгжүүлэх бололцоогоор дяг. Ер нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн өгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль маань хувь лсэн пропорциональ системээр хийгдсэн. Түүнийг энэхүү н 17, 18, 29, 32, 35 дугаар зүйлүүд ч үүнийг баталсан. лыд оролцогч иргэн хоёр санал өгч байгаа нь үнэн.

Нам, эвслийн нэрийн жагсаалтаар орон нутаг, нэгжийн төл хангагдсан. Сонгуулийн эцсийн үр дүн намуудад өгсөн сан пропорциональ тогтолцооноос хамаарч байгаа юм" гэжээ.

ХЯНАВАЛ:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгч Хурлын сонгуулийн тухай хууль нь иргэд өөрсдийн төлөөлөгч сонгох пропорциональ системд үндэслэсэн нь тогтоогдов.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгч Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 заалтууд "Төрийн хэрэгт шууд оролцох /сонгогдож/ төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах х оролцох, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх" иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан гэх үндэслэл тогтоогд байна.

3. Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгч Хурлын сонгуулийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүй 1, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн гэж үзсэн иргэн Т. Ядамсүрэнгийн хүсэл хангах үндэслэлгүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн ху Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай ху 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгч хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 хэсгийн " ... иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас ба хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгч бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сон явуулна" гэсэн заалт Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1, 16 д зүйлийн 9, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрч байна.

2. Энэ дүгнэлтийг хүлээн авснаас хойш хэрхэн шийдвэрл тухай хариут Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдв ажиллагааны тухай хуульд заасан хугацаанд ирүүлэхийг Улсы Хуралд уламжилсугай.

| | |
|---|---|
| **ДАРГА** | **Л. БААСАН** |
| **ГИШҮҮД** | **Ж. БЯМБАА** |
| | **Н. ЖАНЦАН** |
| | **Д. ЧИЛХААЖ** |
| | **Ж. БЯМБАЖ** |